75.Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:01/

76.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:01/

77.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:01/

78.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:01/

79.Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. //17:01/

80.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:01/

81.Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:02/

82.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:02/

83.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:02/

84.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:02/

85.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:02/

Холбогдуулан боловсруулсан:

86.Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /17:02/

87.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:02/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:02/

Уг асуудлыг 17 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хуулийн төсөл эцэслэн батлах /Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Сүрэнхорол, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн комиссын гишүүн Г.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 15

Бүгд: 51

70.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 11

Бүгд: 52

78.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 15

Бүгд: 52

71.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 14

Бүгд: 52

73.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 15

Бүгд: 52

71.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 16

Бүгд: 52

69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Г.Занданшатар: Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 13

Бүгд: 52

75.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Г.Занданшатар: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 11

Бүгд: 51

78.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Г.Занданшатар: Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хаалт

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга С.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, мөн газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга С.Алтанхуяг, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Батманлай, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Гадаад харилцааны хэлтсийн Ц.Жамбалдорж, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга бөгөөд шадар туслах С.Зоригт, Парламентын сурталчилгаа, мэдээллийн төвийн дарга Л.Нинжжамц нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон хаалтын ажиллагаанд оролцогсад босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулган хаасныг мэдэгдэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 37 минут үргэлжилж, 76 гишүүнээс 56 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 09 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх 8 асуудалтай. Танилцуулъя.

Эхлээд хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 11 төслийг эцэслэн батална.

Хоёрдугаарт, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Дөрөвдүгээрт, Хуулийн төсөл эцэслэн батална. Нийт 5 төсөл байгаа.

Тавдугаарт, “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батална.

Зургаа, Баталсан хууль тогтоолуудын эцсийн найруулгыг сонсоно.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээлэл. Хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, зах зээл дэх төрийн оролцоог хялбаршуулах хүрээнд хийгдэх арга хэмжээнүүдийн талаар төлөвлөсөн байсан.

Наймдугаарт, Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хаалт хийнэ.

Чуулган завсарлаж, бүх Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо ажиллаж, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлууд, Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа боловсролын багц хууль, нийгмийн даатгалын багц хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын хууль, авлигатай тэмцэх багц хууль гэх мэтчилэн энэ хувийн хэвшлийг дэмжих, худалдаа, аж үйлдвэрийг хөгжүүлэх, эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр батлах багц хуулиуд гэх мэтчилэн энэ хуулиудын талаар ард иргэдийнхээ саналыг сонсоно. Ард түмнээ сонсох аян өрнүүлнэ. Ийм зорилгоор завсарлаж байгаа.

Ингээд хаврын ээлжит чуулган эхлэхэд энэ хуулиудын талаар бүх ард иргэдийнхээ саналуудыг сонссон, хэлэлцүүлэг хийсэн, бүх Байнгын хороод шүүсийг нь шахсан, бөөсийг нь түүсэн, хуулийн төслүүдийг ард иргэдийнхээ санал дээр үндэслэсэн, шинжлэх ухааны тооцоололтой судалж боловсруулсан ийм хуулийн төслүүдийг хэлэлцэх шаардлагатай.

Ийм учраас намрын ээлжит чуулганыг завсарлуулж ажлын хэсгүүд

болон бүх гишүүд тойрогтоо ажиллана шүү. Гадаад дотоод явахгүй. Зөвхөн тойрогтоо ажиллаж ард иргэдийн саналыг сонссоно. Тойрогтоо яах вэ. Иргэдтэй уулзана. Заавал тойрогт гэхгүй. Нийслэлийн, дүүргийн хороогоор явж. Мөн орон нутагтаа ажиллана.

Ийм учраас Монгол Ардын намын бүлгийн санаачилгаар гадаад томилолтыг хориглох тухай захирамж гарсан болохыг мэдэгдье.

2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Засгийн газраас Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай ХГ/198 тоот албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Албан ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулж өгөхийг хүсье.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан гэж ээ.

Ингээд Хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, зах зээл дэх төрийн оролцоог хялбаршуулах хүрээнд хийгдэх арга хэмжээнүүдийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хэлэлцэх асуудлын дарааллаас хойшлуулж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу өчигдөр 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа асуудал нэмэх, хойшлуулах, дараалал өөрчлөх, горимын санал гаргах бол, асуудал гаргах бол үндэслэл бүхий саналаа бичгээр эрүүлнэ гэж заасны дагуу Бөхчулууны Пүрэвдорж гишүүн чуулганы хуралдаанд асуудал нэмэх горимын санал гаргахад тул үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуудал нэмэх горимын саналаар үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая.

Хөдөө орон нутагт ажиллах талаар Их Хурлын даргын энэ санаачилгыг маш дэмжиж байна. Завсарлагаар ийш тийшээ ингээд явчихдаг шүү. Орон нутагтаа очиж сайн ажиллаарай. Айлаар ороорой. Багуудаар зочлоорой. Тэгж байж энэ хаврын чуулганаар хэлэлцэх тэр хуулиуд дээр тодорхой иргэдийн саналыг авчирч тусгах нь хамгийн чухал байгаа.

Тэгэхээр хаврын чуулганаар нийгмийн даатгалын багц хууль орж ирж байгаа.

Үүнийг яаралтай оруулсан Т.Аюурсайхан сайд, мөн түүнчлэн үүнийг маш хурдтайгаар хэлэлцүүлсэн Байнгын хорооны дарга П.Анужин нарт бас талархаж байна.

Хаврын чуулганаар үүнийг батлах эрмэлзэлтэй байгаа. Гэвч Боловсролын багц хууль орж ирээд хоёр жил болж байгаа. Хоёр жилийн турш хэлэлцүүлэг хийж байгаа юм. Яасан ч дуусдаггүй хэлэлцүүлэг юм. Тэгээд түүнтэй адилхан энэ нийгмийн даатгалын багц хуулийг бас дахиад л хаваржингаа намаржингаа хэлэлцээд явчих юм биш байгаа.

Дээрээс нь энэ талаар бас нэлээн сайн мэдлэгтэй С.Чинзориг гишүүн өөр сайд хийгээд явж байгаа. Энэ ингээд цалгардаад алга болох вий.

Тийм учраас ард иргэд, энэ хөдөөгүүр очсон. Цөөхөн нь очих байх л даа. Ардын намаас. Эд нар чинь л гол шийдвэр гарна шүү дээ. Энэ хүмүүстэй

энэ хаврын чуулганаар нийгмийн даатгалын багц хуулийг яаралтай хэлэлцэж хаврын чуулганы эхэнд батлах тухай шаардлагыг тэр хурал дээр нь сайн тавьж өгөөч. Тэгэхгүй энэ хууль хойшлоод байх юм бол 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ гээд, дараа оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ гэнэ. Тэр хооронд дахиад л 20, 30 мянган ахмадууд хохироод үлдэх ийм л нөхцөл байдал руу орчхоод байна шүү дээ.

Ийм учраас яам, Байнгын хороо энэ дээр маш сайн санаачлагатай ажиллах хэрэгтэй. Яг энэ 7-г 5 жил болгох дээр ийм асуудал гараад байна.

Дараагийн асуудал нь болохоор бас бид нарын өргөн барьсан 2018 оноос 7 жилээр бодуулсан тэр хүмүүс энэ зурвасхан хугацаанд Монголын төрөөс болж хохирч үлдэх ёсгүй.

Тийм учраас энэ ахмадуудын тэтгэврийг нөхөж бодох энэ хуулийн байгаа байх.

агуулгыг нь нийгмийн даатгалын багц хуульд оруулж 7 жилээр бодуулсан ахмадуудыг хохиролгүй болгох тэр асуудлыг бас манай ард иргэд, Монгол Ардын намын гишүүдэд сайн шаардаж өгөөрэй. Манай Ардчилсан намынхан ерөөсөө бүгдээрээ дуу нэгтэйгээр үүнийг дэмжиж байгаа. Даанч гацааж байгаа нь Монгол Ардын намынхан байгаа.

Тийм учраас хөдөө орон нутагт ажиллахад нь сайн чихэн дээр нь яншаарай. Сайн хэлж өгөөрэй. Гурав, дөрвөн нөхөр байгаа шүү. Дандаа шон шон гээд ахмадуудын эсрэг юм ярьдаг хэдэн Их Хурлын гишүүн байгаа шүү. Тэрийг нь би энэ групп дээрээ биччихнэ. Тэгээд тэд нарт нь сайн хэлж өгөөрэй.

Г.Занданшатар: Үг хэллээ. Одоо хуулийн төсөл эцэслэн батална. Хуулийн төсөл эцэслэн батлах санал хураалт явуулъя. Тэгээд дараа нь үүнтэй холбогдуулаад асуудал хэлэлцэхэд О.Цогтгэрэл гишүүний үг ирчихсэн

Нэг.Хуулийн төсөл эцэслэн батлах

Хууль эцэслэн батална. 11 хууль байгаа.

Эрхэм гишүүд ээ, хуулиудыг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцсийн баталсанд тооцно гэж заасан.

Ингээд санал хураалт явуулна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Ингээд өнөөдрийн эхний санал хураалт

учраас бүртгэлийн санал хураалт явуулъя.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний дуудъя. Энд байсан. Б.Бат-Эрдэнэ сайд. Эрхэм гишүүн Хавдисламын Баделхан, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Хүрэлбаатарын Булгантуяа, Тогмидын Доржханд. Нанзадын Наранбаатар гишүүн байсан. Чимэдийн Хүрэлбаатар сайд, Болдын Жавхлан сайд.

Мөнхөөгийн Оюунчимэг Монгол Ардын намын бүлгийн дэд дарга. Болж байна уу?

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

Нанзадын Наранбаатар гишүүн горимын санал гаргана.

Н.Наранбаатар: Саналаа өгч амжсангүй учраас хүчингүй болгоод дахиж санал хурааж өгнө үү.

Г.Занданшатар: Нанзадын Наранбаатар гишүүний горимын саналаар санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Энэ ингээд ажиллахгүй болчихлоо. 69.6 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалт хүчингүйд тооцсон учраас дахин санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

Ард түмнээ сонсох ажлыг хойшлуулья гэвэл ирэх долоо хоногт ер нь сунаж хуралдсан зөв юм шиг байна даа. Пүрэв-Очирын Анужин гишүүн.

П.Анужин: Баярлалаа. Сая сүүлийн хоёр санал хураалт дээр төхөөрөмж ажиллаагүй учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож ахин санал хураалт явуулж өгнө үү. Баярлалаа.

Г.Занданшатар: П.Анужин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. /алх цохив/

Хэмнэлтийн хуулиар хасагдсан. Үүнийг янзлах.

80.4 хувийн саналаар П.Анужин гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Чимэдийн Хүрэлбаатар сайд, Н.Учрал сайд өгөөгүй байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд. Сая энд явж байсан. Дуудья.

Горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулна. С.Чинзориг сайд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалт. /алх цохив/

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль. Энэ хууль эцэслэн батлагдсанаар шүүхийн үйл ажиллагаа гацаж болзошгүй цаг хугацааны нэг эрсдэл байгааг хойшлуулж байгаа. Ганцхан өгүүлбэртэй хууль байгаа. Санал хураалт. /алх цохив/

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Энэ хуулиар яах вэ, нөгөө Шүүхийн хуулиар шүүгчийн туслах заавал хуульч хүн гээд заачихсан. Хуульчийн шалгалт өгөөгүй энгийн мэргэжлийн хүмүүс ажиллаж болж байсан. Туслахуудыг бүгдийг нь хуульч болгочихоор хуульчийн шалгалт өгсөн хүн байхгүй гээд. Шүүгчийн туслах байхгүй болохоор шүүхийн үйл ажиллагаа гацах эрсдэлтэй болсон.

Хуульчлах ёстой гээд. Тэгээд л харин хуулийн төсөлд гишүүдээс санал гаргаад л нэмчихсэн юм билээ.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Энэ ажиллах хүчний хувьд чухал хууль байгаа.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт. /алх цохив/

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүнийх дэмжсэн саналд тооцье.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёолоор санал хураалт явуулъя.

Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Төхөөрөмж ажиллуулж чадсангүй

Г.Занданшатар: Дэмжсэн хүн байна шүү дээ.

С.Бямбацогт: Тийм. Дэмжсэн. Горимын саналаар санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданшатар: Энэ чинь ингээд дэмжсэнд тооцчихож болох уу? Болно оо, болно. Чи дэмий юм яриад бай.

С.Бямбацогт: Надаас болсон. Тийм.

Г.Занданшатар: С.Бямбацогт гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

78.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн. Сайн байна уу? Та картаа уншуулчих. Тэгээд санал хураалт явуулъя. Санал хураалт явуулахад бэлдье.

Горимын санал дэмжигдсэн учраас Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. /алх цохив/

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн

төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Эцэслэн батлах дээр үг байхгүй. Эцсийн хэлэлцүүлэг. Бүгд дууссан.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Дараагийн асуудалд орно.

***Хоёр. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.11-ний өдөр өргөн
мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.21-д заасныг баримтлан тогтоолын хэрэгжих хугацааг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх нь зүйтэй гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусгаж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны танилцуулга зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн тогтоолын төслийг эцэслэн баталж өгнө үү.

Анхаарал тавьсан баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал байна. Гуравны хоёроор.

1.Тогтоолын төслийн 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

5.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт. /алх цохив/

Мөрдөх хугацааг л хойшлуулж байгаа юм байна.

76.6 хувийн саналаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хурааж дууслаа. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулья. /алх цохив/

80.9 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Ингээд 92 үнийг дэлхийн зах зээлийн үнээс хямдралтай байх нөхцөл мөрдөгдөж байгаа юм. Тийм ээ.

Дараагийн асуудалд орно.

Олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Энхтайваны Бат-

Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Танилцуулга. Бэлэн болоогүй бол хэл л дээ. Дараагийн асуудлаа хэлэлцэж байхгүй юу. Энэ асуудлыг хойшлууллаа. /алх цохив/

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудал. “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо намын бүлэг, Байнгын хороо хууль санаачлагчийн саналыг үндэслэн дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батлах зохицуулалтын дагуу Байнгын хороодоос

36, Монгол Улсын Засгийн газраас 66, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс 37, Ардчилсан намын бүлгээс 31 санал ирсэн бөгөөд давхардсан тоогоор нийт 170 хууль, тогтоолын төслийн саналаас Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль, тогтоолын төсөл болон батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан 58 хууль, тогтоолын төслийг тусгалаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлбэл хэлэлцэх асуудлын дараалалд оруулах асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэхээр зохицуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд туссан нэн түрүүнд батлах шаардлагатай хууль, тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгах. Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг батлахдаа ач

холбогдлоор нь эрэмбэлэх хууль, тогтоолын төслүүдийг батлах, хэлэлцэх гэж ангилах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тогтоолын төсөлд тусгах талаар санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Сандагийн Бямбацогт гишүүн. Нэр тасаллаа. Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт асуулт асууна.

С.Бямбацогт: Энэ хаврын ээлжит чуулганаар Улсын Их Хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалт орж ирж байгаа.

Тэгээд энэ жагсаалтыг харж байхад бид 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд 2020 оны 01 дүгээр сард санагдаж байна. Улсын Их Хурлын 02 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсний дагуу 40 орчим хууль батлах ёстой. 40 орчим хууль. Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын тухай хууль гээд нэлээн олон. Үндэсний аудитын тухай хууль гээд олон хууль баталсан.

Одоо батлагдахгүй бас хүлээгдэж байгаа нэлээн хэдэн хууль байгаа. Энэ хуулиудаа баталмаар байх юм. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт заасныхаа дагуу. Тухайлах юм бол одоо Үндэсний баялгийн сангийн тухай хууль. Монгол Улсын газрын хэвлэлийн баялаг ард түмний өмч байна. Төрийн мэдэлд байна. Төрийн нийтийн өмч байна. Монгол Улсын ард иргэд мэдэх эрхийнхээ хүрээнд байгалийн баялгийн сөрөг нөлөөлөлгүй байгалийн баялгаасаа хувь хүртэнэ гээд ингээд Үндсэн хуульд оруулчихсан. Гэсэн мөртөө хүртэж чаддаггүй. Үүнийг хүртэхийн тулд энэ Үндэсний Баялгийн сангийн тухай хуулийг батлах ёстой. Энэ хууль маань орж ирдэггүй.

21 аймгийг хот болгоно. Дархан, Эрдэнэтийг хот болгоно гээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Өнөөдөр 21 аймгийг хот болгох асуудал яригддаггүй. Нөгөө Дархан, Эрдэнэтийг хот болох асуудал ерөөсөө яригддаггүй. Энэ хуулиа бас оруулмаар байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль гэх мэтчилэн нэлээн хэдэн хууль байгаа.

Энэ хуулиудаа хэзээ, яаж оруулах вэ? Хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон уу, ороогүй юу? Ороогүй бол оруулах талаар бид бас яаж анхаарах ёстой вэ? Энэ талаар Төрийн байгуулалтын байнгын хороон дээр яригдсан юм болов уу, яригдаагүй юм болов уу? Энэ талаар нь хариулж өгөөч.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултад хариулья.

М.Оюунчимэг: С.Бямбацогт гишүүний асуултад хариулья.

Сая энэ Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороогоор баталж дэмжсэн тогтоолын төслийн гуравт нь “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд туссан хууль тогтоомжийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэ даалгасугай гээд маш тодорхой заагаад оруулчихсан байгаа.

Тэгэхээр таны саяын хэлсэн асуудлууд энэ хаврын чуулганаар хэлэлцэх асуудалд орох, нээлттэйгээр Засгийн газрын тэргүүнд даалгасан тогтоолд тусгагдсан байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүний хөндсөн, тодруулсан асуулт Байнгын хороогоор хэлэлцэх үеэр яригдсан.

Нэн ялангуяа 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 40 хуульд өөрчлөлт оруулахаас одоо 13 хуульд өөрчлөлт оруулаад, 2022 онд, өнгөрсөн онд гэхэд энэ Хянан шалгалтын тухай хууль хэрэгжиж эхэлж байна. Хянан шалгалтын тухай хууль хэрэгжиж эхэлснээс одоо энэ нээлттэй сонсгол, иргэний хяналт, Улсын Их Хурал баталсан хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийг хянаж шалгах шинэ соёл нөхцөл хэрэгжиж эхэлж байна шүү дээ.

Тэгэхээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт ороод л бүх юм сайхан болчихдог юм биш. Үүнийг чинь органик хуулиар болоод, процессын хуулиар болоод, үүнийгээ сайжруулаад ингээд долоо, найман жил явж байж энэ хуулийн үр дүн гардаг.

Одоо Хянан шалгалтын хууль бол одоо дөнгөж хэрэгжиж эхэлж байгаагийн илрэл бол энэ нээлттэй сонсгол одоо явагдаж байгаагийн. Гэтэл бусад хуулиуд, Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсангүй. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бас байгалийн баялгийн үр өгөөжийг дийлэнх нь ард түмэнд оногддог байх ийм эрх зүйн орчныг бүрдүүлж, олон нийтийн хяналттай, ирээдүй хойч үедээ болон одоо үед тэгш шударга, хүртээмжтэй ийм Ашигт малтмалын хууль, Үндэсний баялгийн сангийн хууль гарах эрх зүйн үндсийг тогтоох шаардлагатай гэсэн.

Тэгтэл одоо болтол Үндэсний баялгийн сангийн хууль өргөн баригдаагүй, хэлэлцэгдээгүй байна.

Улс төрийн намын тухай асуудал өнөөдөр хэлэлцүүлгүүдээр маш их ярьж байгаа. Улс төрийн нам, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль ажлын хэсэг байгуулсан. Одоо хүртэл өргөн баригдахгүй байна, хэлэлцэгдэхгүй

байна. Үүнийг ард иргэд нэхэж байна. Энэ хуулиудыг хэлэлцье гэж Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцсэн боловч өргөн баригдаагүй хуулиудыг жагсаалтад оруулж болдоггүй гэсэн ийм үндэслэлээр жагсаалтад ороогүй.

Тэгэхээр нь энэ 2, 3 дугаар заалтуудаа нэмж эдгээр хуулиудыг, бусад одоо энэ Шүүхийн тухай хууль ч гэсэн бүрэн төгөлдөр хэрэгжих, Эрүүгийн хууль ч гэсэн цаашаа үндэстэй хэрэгжих, хөгжлийн бодлого тогтвортой байна гээд заачихсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль батлагдсан боловч үүний хэрэгжилт нь Эдийн засаг, хөгжлийн яам дөнгөж сая үйл ажиллагаагаа энэ оноос эхэлж байна.

Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль, Нийтийн эрүүл мэндийн тухай хуулиуд байна. Гэх мэтчилэн олон хуулиуд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт амилаагүй байгааг бид хаврын чуулганаараа онцгой ач холбогдол өгч, гишүүд ч гэсэн санаачилж

Дөрөв. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Одоо түрүүний асуудалд орно. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

ажлын хэсэгт ажиллаж энэ хуулиудын талаар ард түмнээ сонсох аяны хүрээнд гишүүд төслийг авч хэлэлцүүлэг хийнэ.

Улс төрийн намын тухай хууль дээр Ц.Мөнхцэцэг гишүүний төсөл бэлэн болчихсон. Холбогдох газруудад хүргүүлчихсэн байгаа. Үүнийгээ бас хэлэлцүүлэх хэрэгтэй. Хэлэлцүүлэг зохион байгуулах хэрэгтэй. Хэд хэд зохион байгуулсан гэж ойлгож байгаа.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна.

Санал хураалт. /алх цохив/

57.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй

байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан хэлэлцсэн болно.

Тус Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед хуралдаан даргалагчаас төслийн холбогдох зарим зүйл, хэсэг, заалтыг уялдуулах талаар гүйцээн боловсруулах чиглэл өгч, Байнгын хороонд шилжүүлсний дагуу зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг үндэслэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон нийт гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед санал хурааж дэмжигдсэн боловч дахин санал хураалгах шаардлагатай саналыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг үндэслэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь буюу 81.8 хувийн саналаар дэмжлээ.

Хэлэлцүүлгийн явцад эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн дээрх хуулийн

төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Тус Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дарааллын шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Д.Сарангэрэл гишүүнээр, Цэрэнжамцын Мөнхцэцэг

гишүүнээр тасаллаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах гэдэг их зөв нэртэй, гоё нэртэй ийм хууль орж ирээд олон нийтийн сүлжээ чинь олон нийт чинь өөрөө энэ дээр бас эсрэг байр суурь илэрхийлээд байна л даа.

Мэдээж энэ хуульд сайн тал, муу тал аль аль нь бас байгаа. Тэгэхдээ өчигдрийн тэр хэлэлцүүлгийг харж байхад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд чинь энэ хуультай чинь бас санал нэгдэхгүй байгаад байна. Энэ хуулийн зарим зүйл, заалтуудтай.

Тэгэхээр энэ дотор маш олон зүйлүүд бас яригдаж байна. Тэр тусмаа энэ сошиалын болоод хэрэглэгч гэдэг чинь бараг 3 сая хэрэглэгч байхад энэ хууль чинь тэр оролцогч талуудынхаа санаа бодлыг тусгалгүйгээр, хэлэлцүүлэг хийгдэлгүйгээр нэг өдрийн дотор өргөн баригдаад хэлэлцээд эцсийн хэлэлцүүлэгт орчихдог бас яг ийм байж бас болох уу?

Засгийн газраас яаралтай дэгээр хэлэлцэх асуудлууд байдаг. Энэ үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар яаралтай горимоор гэж байдаг болохоос биш яг одоо энэ асуудал өөрөө яг үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай яг ямар холбоотой болчихоод ингэж яаралтай горимоор орж ирэх болчихоод байгаа юм бэ.

Ийм учраас яг энэ хэлэлцэх эсэх нь нэгэнт дэмжигдчихсэн энэ хуулийн төслийг одоо чуулган завсарлаад ажлын хэсэг гараад, ажлын хэсэг сайн муу талаас нь тал бүрээс нь ярилцаад хаврын чуулганаар үүнийг нэлээн тийм нухацтай ярилцаж хэлэлцэх нь зүйтэй гэж Ардчилсан намын бүлгийн зүгээс бас

үзэж ийм байр суурьтай байгаа. Үүн дээр бас байр сууриа нэгтгэх, олон нийтийн санаа бодлуудыг тусгах олон ийм хэрэгцээ шаардлагууд байна гэж бид бүгдийн зүгээс үзэж байгаа юм.

Ийм учраас Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрх, үүргийн дагуу Ардчилсан намын бүлгээс энэ хуулийн хэлэлцүүлгийн явцаас 5 хоногийн завсарлага өгөөч гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Энэ чинь ингээд Ардчилсан намын бүлгээс завсарлага авах хүсэлт гаргалаа. Ням-Осорын Учрал гишүүн одоо үг хэлнэ.

Н.Учрал: О.Цогтгэрэл гишүүн бас санал хэллээ. Тэгээд би ажлын хэсэг дээр Хүний эрхийн Үндэсний Комисс, хэвлэл мэдээллийн байгууллагууд, нэр бүхий сэтгүүлчид, олон нийтийн байгууллагуудаас тодорхой саналуудыг өгсөн.

Энэ хууль 2017 онд анх боловсруулагдсан. 10 гаруй л хууль тогтоомжууд байсан юм билээ. Тухайн үеийн Хууль зүйн яамнаас ч боловсруулж байсан.

Манай С.Одонтуяа гишүүн ч гэсэн Хүүхэд хамгааллын хууль дээр өөрчлөлт оруулна гээд. Дээрээс нь миний хувьд ч гэсэн Хүүхдийг тэдгээрийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс хамгаалах тухай хууль гээд олон хуулийн төслүүд байсан.

Холбогдох судалгаанууд, холбогдох байгууллагуудын саналууд олон улсын байгууллагуудын судалгааны хувьд маш их хангалттай бүрдсэн. Олон ч хуулийн төсөл байсан учраас, бас олон жил хүлээгдсэн хуулийн төслийг ингээд холбогдох саналуудыг аваад оруулж ирсэн.

Хүний эрхийн комиссын зүгээс өнгөрсөн хугацаанд бас ажлын хэсэгт орж тодорхой саналуудаа хэлсэн. Тэгээд үүнтэй холбогдуулаад өчигдөр ч гэсэн бас тодорхой саналууд гарсан учраас жишээ нь цахимаар залилах гэмт хэрэг бол нэг жилийн хувьд 93.8 хувиар, цахимаар хүүхдэд садар самууныг сурталчлах гэмт хэрэг 2.8 дахин өссөн. Эрүүгийн хуулийн 34 төрлийн гэмт хэргийн 94 хувь нь цахим орчинд үйлдэгдэж байгаа гэдэг судалгаанууд байгаа.

Тийм учраас өдөр ирэх тусам л энэ тоо нэмэгдээд байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийг даруй батлаад гэмт хэрэг болохоос нь урьдчилан сэргийлэх зорилгоор контентууд дээр нь холбогдох үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай харилцах сувгаа тодорхой болгоё гэхгүй бол сүлжээний үйлчилгээ үзүүлж байгаа тэр фэйсбүүк гэж жишээ нь компани бол Монгол дахь сувгаа тодорхой болгоо. Бид нартай хамтарч ажиллаач ээ. Европын Холбоо өнөөдөр 28 улстай акт үйлдээд энэ хуулийнхаа дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Герман Улс, Япон Улс хүртэл энэ үйл ажиллагаагаа явуулж байна.

Тийм учраас та нар бас хууль эрх зүйн орчинтой болох юм бол бид нар төлөөлөгчийн газраа байгуулаад гэмт хэрэг болохоос нь урьдчилан сэргийлэх ажлыг хамтарч хийе гэдэг саналуудыг бас тодорхой түвшинд бид нар ярилцсан учраас энэ хуулийн төслийг оруулж ирсэн.

Өчигдрийн хувьд Хувь хүний мэдээлэл хамгаалах хууль, Татварын ерөнхий хуультай холбогдуулаад төрийн албан тушаалтан буюу нийтийн албан

тушаалтан хувь хүний мэдээллийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр олон нийтэд нийтэлдэг, банк санхүүгийн гүйлгээнийх нь тайлан тавьдаг. Иргэд иргэдийнхээ мэдээллийг ингэж зөвшөөрөлгүйгээр нийтэлдэг байдал байж болохгүй гэдэг утгаараа хуультай нийцүүлсэн 6.3 дахь заалтыг бас нийгэм буруу ойлгож шүүмжилсэн.

Тийм учраас өнөөдөр эцсийн хэлэлцүүлэг дээр эцсийн найруулга өгөх Их Хурлын даргын чиглэлийн дагуу 6.3 гэсэн энэ заалтыг хассан. Мөн нэр бүхий сэтгүүлчдийн санал болгосноор энэ харгалзаж үзэх үндэслэл дээр олон нийтэд нөлөө бүхий этгээдүүд гэдэг энэ заалтыг энэ хуулийн заалтаас мөн бас хассан байгаа.

Мөн гүтгэх, доромжлох гэдэг заалт өөрөө хэвлэлийн эрх чөлөөнд халтай юм гэдэг тодорхой санал өгсөн учраас цахим гадуурхал дотроо буюу тэр хүнийг заналхийлэх гэдэг агуулгаараа энэ явж болох учраас заавал энэ заалт байх шаардлагагүй гэдгийг угаасаа анхнаасаа энэ хуулийн төсөл орж ирэхдээ энэ гүтгэх, доромжлох гэдэг ийм ерөнхий агуулгыг хуульчилж өгөөгүй.

Тэгэхээр зөрчилтэй контент дотор 11 заалт хамаарагдаж байгаа учраас энд ямар ч асуудал, бэрхшээл үүсэхгүй. Хэвлэлийн эрх чөлөөнд халтай биш. Төрийн үүргийг 80 хувь хуульчилсан. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлсэн. Мөн хохирогчдыг хамгаалах ийм хууль болсон.

Өнөөдөр ч гэсэн 5 өмгөөлөгч надад хандсан. Манай хүүхдүүдэд садар самууныг сурталчилсан. Үүнээс чинь болоод ийм асуудал үүсчихсэн байна.

Тэгээд би одоо бол тэр троллчдыг буюу уул, усны, хадны зурагтай байгаа

хүн биш хүн хогнуудыг би шүүмжлээд байгаа шүү.

Тийм учраас тэр троллчид бол одоо битгий энэ асуудалд оролцоод бай. Ард түмэн харж байна. Цахимаар залилах гэмт хэрэг цаг минут тутам өсөж байна.

Тийм учраас энэ хуулиа гаргаад тэр олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч нарийгаа хамтарч ажиллаад.../минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хороогоо тодруулах асуудал байна уу?

Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Н.Учрал гишүүний тайлбарыг сонслоо.

Тэгээд Ардчилсан намын бүлгийн зүгээс нөхцөл байдлыг тодруулж ярилцах шаардлагатай. Үндэсний аюулгүй байдлын талаасаа энэ дээр учир шалтгаанууд олон зүйл байгаа гэсэн мэдээллүүд ирж байгаа учраас бид бүхэн та, Их Хурлын дарга үдээс хойш хүртэл завсарлага өгөөч ээ.

Бид бас дотооддоо нэг зөвлөөд шийдвэр гаргачихъя.

Г.Занданшатар: Баярлалаа. Ингээд за яах вэ, 14.00 цаг хүртэл завсарлага өгье.

О.Цогтгэрэл гишүүн Ардчилсан намын бүлгийн гаргасан саналын дагуу бас сайн ярилцаад одоо энэ санал хураах гэж байгаа асуудлууд. Миний ойлгож байгаагаар тэр нийтийн албан тушаалтан энэ тэртэй хамааралтай заалтуудыг Байнгын хороо хасчихсан.

Ер нь иргэний нийгмийн сүлжээгээр гарч байгаа юмнуудыг харчихсан. Тэрийг бас зөв ойлголт өгөх үүднээс Байнгын хороогоо төлөөлөөд Дамдины Цогтбаатар гишүүн бас Хүний эрхийн комиссынхонтой ч ярилцсан. Тэр зөвлөл энэ тэрд Хүний эрхийн комисс, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд ороод хяналт тавьж ажиллахаар юм билээ шүү дээ. Тийм ээ. Тийм өөрчлөлтүүд хийсэн.

Тэгээд хүний эрхийн талаасаа зөрчил гарахгүй байх талаасаа, аюулгүй байдлаасаа ингээд ойлгосон шийдэлд хүрсэн гэж ойлгосон. Тэрийгээ тайлбарлачихъя.

Тэгэхдээ Ардчилсан намын бүлэгт үдээс хойш хүртэл гаргасан саналын дагуу завсарлага өгье. 14.00 цаг хүртэл.

Дамдины Цогтбаатар гишүүн Байнгын хороо хариулья. Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр яг энэ хуультай холбогдуулаад олон нийт бас болгоомжлол ярьж байгаа. Түүнтэй холбогдуулаад ялангуяа Хүний эрхийн комиссыг өчигдөр харин ярьж байж энэ хуультай холбогдуулаад зарим шийдвэр гаргах дээр нь Хүний эрхийн комиссын оролцоотойгоор журмыг нь боловсруулж, Хүний эрхийн комиссын саналыг авч журам боловсруулах энэ заалтууд орж ирсэн шүү.

Тэгэхээр энэ дээр би нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Манай ер нь Монголын төр нэг соёлыг. Энэ бол бүр соёл болоод хэвших ёстой. Аливаа хүний эрх рүү халдаж болзошгүй асуудал гаргах гэж байгаа бол. Бүр харахад энгийн юм

шиг боловч тийм тусмаа энгийн юм шиг харагдаж байгаа л бол Хүний эрхийн комисстой заавал ярьж байж саналыг нь авч сурах хэрэгтэй.

Одоо энэ дээр бүр саналыг нь авах байтугай журам боловсруулахад тэр Хүний эрхийн саналыг харгалзахаар оруулж ирсэн байгаа.

Тэгээд тэр дотроо нэг зүйлийг хэлмээр байна. Хууль тогтоогчдын зүгээс хүсэж байгаа юм нь юу вэ гэхээр төрийн байгууллагуудын энэ яг журамтай холбогдсон үйл ажиллагаа, боломж нээгдэх тэр цонхыг нарийсгаж өгөөд зөвхөн экстермизм, терроризмын эрсдэл байгаа үед. Тэгэх юм бол Хүний эрхийн комисстойгоо ярьж байгаад энэ тодорхой үйл ажиллагаа орно уу гэхээс өөр юман дээр хүний эрхийн талдаа хүний эрх чөлөөний талдаа ажиллах ёстой шүү гэдэг энэ агуулгын өөрчлөлтүүдийг оруулж өгсөн байгаа.

Тэгээд энэ дээр би зүгээр нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Үнэхээр энэ үндэсний аюулгүй байдал гэдгийг заримдаа төрийн байгууллагууд буруу ойлгоод байгаа юм. Энэ чинь төрийн аюулгүй байдал гэж хэлээгүй. Үндэсний аюулгүй байдал гэдэг чинь юуг хэлээд байгаа вэ гэхээр төрийн аюулгүй байдал, дарга нарын сандал суудлын аюулгүй байдал биш. Энэ улс орны нийгмийн тогтолцооны тухай асуудал яриад байгаа юм.

Тэгэхээр бид энэ нийгмийн тогтолцоонд хамгийн чухал юм чинь юу вэ гэхээр урьд өмнө нь бид нар үндэсний аюулгүй байдал гэхээр газар нутгийн бүрэн бүтэн байдал, засаглах бүрэн эрх, хараат бус байдал гэж ярьдаг байсан бол XXI зуунд ардчилсан Үндсэн хуулийн доор энэ үндэсний аюулгүй байдал дээр чинь нэг чухал зүйл нэмэгдсэн байгаа

шүү. Ард иргэдийн эрх чөлөө. Хэрэв ард иргэдийн эрх чөлөөнөөс нэг ямх алдагдаж байгаа бол газар нутгаас нэг ямх алдагдаж байгаатай адилхан том аюул гэдгийг бид нар үзэх ёстой.

Тэгэхээр төрийн байгууллагууд энэ төрийн аюулгүй байдал биш энэ иргэдийнхээ эрх чөлөөний аюулгүй байдалд, тэрийг хамгаалах үндсэн үүрэгтэй шүү. Би энэ гартаа Үндсэн хууль бариад сууж байна.

Тэгээд энэ Үндсэн хууль дээр үг нь эхлэхдээ “Монголын ард түмэн бид” гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ төрийн хөгийг бүх үндэслэлийг нь тавьж явж байгаа юм ард түмэн. Тэр дарга нар нь жинхэнэ ард түмэн. Эд нарыгаа хамгаалж байх ёстой байхгүй юу. Тэгээд энэ талаасаа манай төрийн байгууллагууд ер нь цаашдаа бас анхаарч ажиллаж байх ёстой л гэж хэлмээр байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Ер нь энэ асуудал бол нухацтай хандах нь зүйтэй. Манай үндэсний аюулгүй байдал ер нь баталгаа нь бол ардчилал, хүний эрх, эрх чөлөө.

Тийм учраас энэ хууль бол яг нэртэйгээ адил олон нийтийн сүлжээнд хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэгдэж байгаа. Хүний эрх, эрх чөлөө цаанаа 8900 гаруй гэмт хэрэг гараад. Цаана нь бүртгэгдээгүй өчнөөн гэмт хэрэг гарч байгаа.

Тэгээд хүний эрхийг хамгаалахдаа л гол нь чиглэгдэх ёстой. Хүмүүсийн шүүмжлэх, нэрээрээ ил тод шүүмжлэх, мэдээллийг ил тод болгох, шүгэл үлээх эрхийг хязгаарлаж болохгүй. Энэ бол бусад хуулиар ч гэсэн хүний эрх хамгаалагдаж байгаа.

Энэ хууль дээрээ харин тэр троллууд, гадаад, дотоодын сонирхлоор ард иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулсан төөрөгдүүлсэн, хулгайч нарыг нуугдуулсан ийм бас зохион байгуулалттай байж болзошгүй ийм хэргүүд маш их гарч байгаа. Ийм сошиал халдлага, кибер аюулгүй байдлын халдлагууд, хакераас авхуулаад. Тэгээд хиймэл оюун ухаанд тулгуурласан нийгмийн сүлжээний ийм бүр контент бүтээдэг аргачлалууд гаргачихсан. Хүмүүсийг бухимдуулдаг, дэврээдэг, өөр тийшээ анхаарлыг хандуулдаг, төөрөгдүүлдэг. Хууль хяналтын байгууллагуудыг ч гэсэн төөрөгдүүлдэг,

дайрдаг давшилдаг ийм эерэг, сөрөг тал нийгмийн сүлжээнд байгаа.

Тэгэхдээ бид хамгийн гол нь хүний эрх, монгол хүний үг, үзэл бодлоо илэрхийлэх энэ эрх чөлөөг хязгаарлахгүй. Харин тэр нь бодитой хүрдэг байх эрх чөлөөг хангахад энэ хууль чиглэх ёстой. Ийм учраас ингээд үдээс хойш 14.00 цаг хүртэл Ардчилсан намын бүлэгт завсарлага өгч байна.

Тэгээд энэ асуудлыг нухацтай ярилцаад ингээд 14.00 цагаас үргэлжлүүлж шилжье. Ингээд 14.00 цаг хүртэл чуулганы нэгдсэн хуралдаан завсарлалаа. /алх цохив/

ЗАВСАРЛАГА

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ /үргэлжлэл/

Г.Занданшатар: Өдрийн амгаланг айлтгая.

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ингээд чуулганы хуралдаанаа үргэлжлүүлнэ. Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл завсарлага авсан байгаа. Завсарлагын хугацаа дууссан байна. Ингээд завсарлага дууссантай холбогдуулж Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах гэдэг нэртэй мөртлөө хүний эрхийг зөрчсөн байж болох үндэслэл бүхий энэ хуулийн төсөл дээр Ардчилсан намын бүлэг завсарлага авсан.

Үндэслэлүүдийг бид дахин бүлгээрээ хэлэлцлээ. Маш олон зүйл, заалтууд хүний эрхийг зөрчсөн, дордуулсан байх ийм магадлал байна гэдэг дээр бүлгийн гишүүд ингээд санал нэгдэж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс ч ийм байр сууриудтай байгаа юм байна. Тэр зөрчил бүхий контентууд гэдэг нь өөрөө тэрийг хэн тогтоох юм. Маш субъектив нөхцөл байдлуудтай. Хэргийг хэн тогтоох юм. Энэ чинь одоо шүүх эрх мэдэлд халдаж байгаа юм уу.

Ер нь том утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийг нь зөрчсөн байх ийм агуулгуудтай. Тэнд төрийн албаны нэг бүтэц гарах юм байна. Төрийн албаны бүтцээс үүнийг бүгдийг нь хянаад сууж байх юм байна. Тэндээс энэ нь зөрчилтэй, энэ зөрчилгүй байна. Үүнийг хаана, үүнийг ингэнэ гэдгийг төрийн албаны

хэдэн алба хаагчид сууж байгаад шийдэх юм байна. Ийм ийм олон зүйл заалтууд байна. Би эндээс ганцхан л. Маш олон зүйл.

Тэгээд энэ хууль өөрөө 02 сарын 01-нээс хэрэгжинэ гэсэн ийм цаг хугацаатай. Маш яаруу. Хоёр хоногийн өмнө өргөн баригдаад, одоо хоёр, гуравхан хоногийн дараа хэрэгжиж эхлэх цаг хугацааны хувьд яагаад ингэж тавьж байгаа юм.

Энэ дээр дагалдан орж байгаа Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 23.2 гээд заалт байна. Үүн дээр кибер халдлага үүсэж болзошгүй, аль эсвэл нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй үед Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн сүлжээг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах арга хэмжээг авч болно гэж байна.

Болзошгүй гэдэг чинь. Онц байдал чинь өөрөө хуулиар зохицуулагдаад онц байдал зарлавал мэдээж хязгаарлалтын арга хэмжээ авах нь хуулиар бүрэн нээлттэй. Гэтэл нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй үед бүхэлд нь болон хэсэгчлэн хязгаарлана. Болзошгүй гэдгийг хэн тогтоох юм. Эрх бүхий албан тушаалтан шийдвэрээ гаргахдаа би ийм нийтийг хамарсан эмх замбараагүй нөхцөл байдал үүсэж болзошгүй гэж үзээд асуудлыг би сэргийлчихсэн гэвэл одоо бас яг юу болох юм.

Тэгэхээр үүн дээр маш олон ийм зүйл, заалтын болоод агуулгын зөрчилтэй маш олон зүйл, заалтыг энэ хууль дээр байна. Энэ хуулийг хойшлуулах, хаврын чуулган руу шилжүүлэх. Болж өгвөл энэ хуулийг буцааж татаж аваад нөхцөл

байдлыг дахин хэлэлцэх, шинээр өргөн барих ийм шаардлагууд байна.

Үнэхээр олон нийтийн хэлэлцүүлэг энэ дээр хийгдээгүй. Энэ чинь одоо яг оролцогч тал, хамаарал бүхий этгээдүүд гэвэл энэ чинь одоо бараг хэдэн зуун мянга биш саяар яригдах ийм хүнтэй хамаатай энэ хуулийн төсөл орж ирж байхад ямар ч хэлэлцүүлэг хийгдэлгүйгээр ингэж шууд эцэслэн батлах үе шат руу нэг хоногийн дотор орчихдог ийм байж болохгүй.

Тэгээд Ардчилсан намын бүлгээс бас үргэлжлүүлэн завсарлага авах саналтай байгаа. Тэгэхдээ энд олон гишүүд асуулт асууж, үг хэлэхээр саналаа өгчихсөн байгаа юм байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын дарга хэрвээ боломжтой бол завсарлагын тухай яриаг бид энэ гишүүдийн үгийг хэлүүлж, асуултыг асуулганы дараа авч болно гэвэл тэр үед Таныг бас үг өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Асуулт хариултаа үргэлжлүүлье. Тэгвэл дараа нь тэгээд Ардчилсан намын бүлгийн завсарлагын асуудлыг дахиж үг өгье.

Одоо асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсэг. 82. Ж.Эрхэмбаатар дэд сайд.

Тэр төвийн саналаар гэж байна шүү дээ. Төвийн саналыг үндэслээд. Тэгээд болзошгүй нөхцөл байдал үүсвэл. Онцгой нөхцөл байдал үүсвэл. Тэгээд зөрчилтэй контентыг. Зөрчилтэй контент гэж юуг хэлж байгаа юм. Тийм ээ. Тэр 6.1.7-д заасан зөрчилтэй контент гэдгээ.

Ж.Эрхэмбаатар: Гишүүний асуултад хариулъя. Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг дагалдуулаад Харилцаа холбооны тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуульд. Мөн Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль, Татварын хуульд дагаж нэмэлт, өөрчлөлт орж байгаа.

Үүний нэг нь Кивер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт орж байгаа. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.15-д заасан үндэсний хэмжээний кибер халдлага үүсэж болзошгүй нөхцөл байдал байна гэж ингэж үзвэл Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв буюу төрийн байгууллагын технологийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий үндэсний төв болох Тагнуулын ерөнхий газрын дэргэд үйл ажиллагаа явуулдаг энэ Үндэсний төвөөс асуудлыг хандана гэсэн үг. Энэ үндэсний төвийн чиг үүрэг бол Кибер аюулгүй байдлын тухай хууль дээрээ заачихсан байгаа.

Тэгэхээр энэ болзошгүй байдал үүслээ гэдгийг мөн яаж тогтоох талаар зохицуулалт нь Кибер аюулгүй байдлын тухай хууль дээрээ байгаа.

Тэгэхээр энэ Үндэсний төв эхлээд тодорхой мэдээлэл, эх сурвалж, одоо ажиллагаа хийсний үндсэн дээр энэ үндэслэл бүхий байдал үүслээ гэж ингэж дүгнэлтээ оруулж ирнэ.

Ер нь ердийн өдрүүдэд өндөр эрсдэл бүхий халдлага, кибер халдлага өдөрт буюу 24 цагт Монгол Улсад нэг 300-аас 500 мянган тохиолдлууд байнга бүртгэгддэг.

Тэгэхээр бүртгэгдэх урсгалаа хянаж байгаад эрсдэл бүхий байдал үүслээ гэвэл Үндэсний төв асуудлаа оруулж ирнэ.

Эсхүл гээд Нийтийн төвийн саналыг үндэслээд мөн нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц нөхцөл байдал үүсэж болзошгүй байдал үүссэн тохиолдолд хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг саналыг оруулж ирнэ.

Энэ Нийтийн төв гэдэг нь Цахим кибер аюулгүй байдлын тухай хуулийнхаа 22 дугаар зүйлд заасан ийм байгууллага байгаа. Энэ байгууллагын удирдлага нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайд байгаа.

Энэ онц нөхцөл байдал, нийтийн эмх замбараагүй байдал гэдэг одоогийн хууль тогтоомжоор дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тодорхойлж оруулж ирдэг. Энэ процессоор орж ирнэ. Ингээд орж ирээд Кибер аюулгүй байдлын зөвлөл дээр уг шийдвэр нь гарна. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүн нь Ерөнхий сайд дарга нь. Нэг дэд дарга нь Тагнуулын ерөнхий газрын дарга. Нэг дэд дарга нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайд. Ийм байгаа.

Кибер аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагаа явуулах журам болоод бүрэлдэхүүний тухай тогтоолын төслийг Засгийн газарт Цахим хөгжлийн яамнаас өргөн бариад хэлэлцүүлэхээр явж байгаа.

Г.Занданшатар: Тэгээд нэг зүйл тодруулчихмаар байгаа юм. Н.Учрал сайд аа.

Тэр Олон нийтийн хяналтын зөвлөл гэж л хэдэн хүн суугаад л үг хэлэх эрх чөлөө хязгаарлах гээд байна гэсэн асуудал.

Тэгэхээр тэр олон нийтийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд Хүний эрхийн комисс байх хэрэгтэй. Үүнийгээ тогтоод протокол тэмдэглүүлээд, хүний эрх зөрчихгүй байх тэр нөхцөлүүдийг хангаад. Мэдээж үндэсний аюулгүй байдлын асуудал байлаа гэхэд хүний эрхийг дээдлэх зарчмаар Хүний эрхийн комисс орох хэрэгтэй. “Глоб интернэшнл” нь ч байдаг юм уу, тэр иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл байх хэрэгтэй. Тийм үү.

Үүнийгээ нээлтэй сонгон шалгаруулаад, нээлтэй зарлаад олон нийтийн хяналтын зөвлөлөө байгуулах юм гэдгээ хэлэхгүй бол. Тэнд чинь ерөөсөө Засгийн газар, сайд нар сууж байгаад контентыг ялгарах гээд байгаа юм шиг буруу ойлголт нийгэмд өгөөд байх шиг байна. Үүнийгээ Н.Учрал сайд тодорхой тайлбарлаад өгөөч. Ням-Осорын Учрал. Намуудын төлөөлөл ч байж болно шүү дээ.

Н.Учрал: Энэ Харилцаа холбооны хууль батлагдаад мөрдөөд энэ чинь 2019 онд Харилцаа холбоо, радио долгион, шуудангийн хуульд өөрчлөлт оруулсан юм.

Энэ Харилцаа холбооны хуульд өөрөө сүлжээнд хяналт тавих, хэсэгчлэн хязгаарлах гэдэг ийм ойлголт байдаг. Яагаад вэ гэхээр энэ нөгөө оператор компаниуд Харилцаа, холбооны зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

Тийм учраас тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа байгууллагуудтайгаа гэрээ байгуулаад эрх үүргийнхээ үндсэн дээр ийм үүргийг угаасаа аль аль талд нь хүлээдэг юм байна.

Тэгээд Харилцаа холбооны хуульд өнөөдрийг хүртэл энэ сүлжээнд хэсэгчлэн болон хязгаарлах гэсэн ийм заалт байдаг. Энэ ерөөсөө шинэ тутам юм биш. Гэхдээ үүнээс би эрсдэлээс юу гэж сэргийлж манай энэ Засгийн газраас барьсан хууль орж ирсэн бэ гэхээр хэн тэр хэсэгчлэн хорих юм бэ гэдэг нь тодорхойгүй. Зүгээр зохицуулах хороо хийх гээд байгаа юм шиг. Хэн хийх гээд байгаа юм.

Эцсийн эцэст энэ шийдвэрийг тэр оператор компаниуд нь өөрсдөө тусгай зөвшөөрөл эзэмшигчийнхээ үүргээр хийдэг байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр яаж байна вэ гэхээр бид харин үүнийг тийм дур зоргоороо аашилж болохгүй. Ийм учраас кибер зөвлөл буюу кибер халдлагад өртсөн эрсдэл бүхий байдал гэдэг бол угаасаа олон улсынх нь ойлголт нь өөрөө байдаг. Жишээ нь, гэмт халдлага өнөөдөр 300 мянгаас 500 мянга. Өдөр тутам энэ гаднын серверээс халдаж байна шүү дээ. Манай өнөөдөр энэ төрийн мэдээллийн үндсэн сүлжээнд. Төрийн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд дээр.

Тэгэхээр анх энэ хуулийг өргөн барихдаа шинэ зөвлөл байгуулж болохгүй. Яагаад гэхээр өдөр тутам кибер халдлага явж байхад үүний 80 хувь нь социал инженерчлэл хийгдээд буюу социалаар дамжиж орж ирдэг юм байна. Нийгмийн сүлжээгээр дамжиж.

Тэгэхээр төрийн мэдээллийн сүлжээ гэдэг чинь өөрөө аюулгүй байх ёстой. Гэмт халдлагаас хамгаалж байх ёстой учраас кибер аюулгүй байдлын тогтолцоог бид өмнөх Кибер аюулгүй байдлын хуулиар бүрдүүлсэн юм.

Энэ Кивер аюулгүй байдлын хууль дээр энэ кибер аюулгүй орчин

зөвхөн хууль хяналтын байгууллага удирдаж болохгүй. Үүнийг Кибер зөвлөл удирддаг байх ёстой гээд Кибер зөвлөлд Хүний эрхийн Үндэсний Комиссыг оруулах.

Дээрээс нь олон нийтийн байгууллагуудыг оруулах. Кибер зөвлөлд хуулийнхан ч орох.

Дээрээс нь энэ харилцаа холбооны асуудлыг эрхэлж байгаа байгууллагуудын төлөөлөл ч орох ийм зөвлөл байгаад дэргэд нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудаа хариуцдаг **National CERT** [Computer Emergency Response Team] буюу олон улсын нэршил. **Public CERT** гэдэг нь Японд гэхэд 50 гаруй Public CERT хийдэг.

Үүнийг хэдэн ч байгууллага хийж болдог. Иргэд хэрвээ халдлагад өртөх юм бол хүсэлтээ явуулдаг. Халдлагад нь хариу арга хэмжээ хийдэг ийм бизнесийн байгууллагууд хүртэл байдаг.

Тэгэхээр бид Public CERT-ыг аутсорсинг хэлбэрээр хэнд ч үүнийг хийж болно гэдгийг Кибер аюулгүй байдлын хуулиараа хуульчилсан. Энэ Public CERT дотор олон нийттэй харилцах нэгж байна. Нэгж нь тэр цахим орчны зөрчилтэй контент гээд байгаа тэр 10 контентыг хүлээж аваад энэ үнэхээр зөрчил байна гэдгийг зөвлөмж гаргаад эрх бүхий байгууллагууд явуулах болохоос биш олон нийттэй харилцах нэгж гэдэг чинь ямар ч тийм хууль хяналтын байгууллага биш. Эрхтэй газар биш. Зүгээр зөвлөмж л өгнө. Мэргэжлийн талаасаа.

Тэгэхээр хууль хяналтын байгууллага ч бай, олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нарт ч бай тусалцаа үзүүлэх ийм зөвлөл байх юм.

Тэгэхээр олон нийттэй харилцах нэгжийг яаж байгуулах ёстой вэ гэхээр нээлттэй сонгон шалгаруулъя гэж байгаа юм. Нээлттэй сонгон шалгаруулаад энэ дээр тэр хүний эрхийн байгууллагууд нь орог, Хүний эрхийн комисс өөрөө орог. Эндээс нь холбогдох байгууллагууд нь орог. Хэвлэл мэдээллийн мэргэжлийн холбоод нь орог, сэтгүүлч нар нь орог.

Энэ олон нийттэй харилцах нэгж дээр тэр олон нийтийн сүлжээнд дагагч өндөртэй тэр нөлөө бүхий этгээдүүдийн төлөөллийг бас оруулъя. Одоо шийдвэртэй ухаалаг постууд хийдэг, нийгмийг зөв зүйлд уриалдаг хүмүүс өөрсдөө ороод хамтарч хэлэлцээд энэ үнэхээр цахим орчинд хүчирхийллийг сурталчилжээ. Энэ үнэхээр цахим орчин, садар самууныг сурталчилжээ, энэ үнэхээр цахим орчинд гадуурхлыг бий болгожээ гэвэл тэд нар өөрсдөө зөвлөмжөө л холбогдох байгууллагад хүргэчихнэ.

Тэгэхээр энэ хууль гарснаараа янз бүрийн байдлаар үйлчилгээ үзүүлэгч нарыг хаах гээд байна, хориглоод байна гэсэн ямар ч ойлголт байхгүй. Тэр фэйсбүүкийг чинь, олон улсын компанийг бид энд зохицуулчихдаг ч юм биш. Харин зөв явуулах үүднээс нь ирээдүй хойчоо бодсон ийм л шийдвэрийг гаргая гэдэг утгаараа нэг хүний эрх мэдэлд биш олон төлөөлөлтэй болгох гэж л энэ заалт орж ирж байгаа болохоос одоо хуульд байгаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо Дамдины Цогтбаатар гишүүн. Алга байна. Одоо эрхэм гишүүн. Дамдины Цогтбаатар гишүүн. Хэлчихсэн үү? Sorry.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би хоёр зүйл асуух гээд байгаа юм.

Энэ чинь хүний эрхийг хязгаарлах чиглэлийн ийм зохицуулалтууд энэ хуулийн төсөлд байна гэж яригдаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгөх бололцоо бий юу? Нөгөө талынх нь юм бол энэ хэвлэл мэдээлэлийн эрх чөлөөг хааж боомилсон ийм заалт байна гэсэн ийм ойлголт байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгөх бололцоо байх уу.

Нөгөө талынх нь нэг асуух гээд байгаа юм бол одоо энэ нийгмийн сүлжээ, энэ социал орчинд болж байгаа энэ үйл явдлаас ямар хортой үр дагаврууд гараад байгаа юм бэ. Ялангуяа өсвөр залуу үеийнхний дунд гэмт хэрэг хүчирхийлэлд уриалах ч байдаг юм уу, эсвэл буруу зан төлөвийг бий болгох чиглэлээр гараад байгаа энэ муу үр дагавартай холбоотой Та бүхэн хийсэн судалгааны ийм зүйлүүд байгаа юу гэж.

Хүний эрхийг баталгаатай хангаж эдлүүлэх талаар бид чинь ардчилсан тогтолцоотой ийм улс орон юм болохоор зэрэг энэ бол хамгийн нэгдүгээрт тавих асуудал мөн үү гэвэл мөн.

Нөгөө талынх нь би нэг санаа зовдог юм бол ялангуяа одоо энэ нийтийн албанд зүтгэж байгаа, ажиллаж байгаа хүмүүс аливаа нэгэн хэрэг асуудалд холбогдох юм уу, хардагдах юм уу, сэрдэгдэх юм бол үүнийгээ үнэн мөнөөр нь ялгуулдаг, ялгадаг. Өөрөө тайлбараа өгдөг юм уу, эсвэл энэ мэдээллийг тараасан хүмүүс нь тэнцвэртэй тайлбар тал талаас нь гаргаж байдаг юм уу, эсвэл одоо бүр хууль хяналтын байгууллагаар

хар цагаанаа ялгуулдаг ийм тогтолцоо руу орохгүй бол бидний энэ сүүлийн 30 жилийн хугацаанд явж ирсэн зүйл ямар байна вэ гэхээр зэрэг ерөөсөө л одоо тэгээд үнэн худал нь мэдэгдэхгүй баахан мэдээлэл гардаг.

Тэгээд сүүлдээ нөгөөдөх нь замхраад алга болдог. Үүний цаад талд хэн хожоод байна вэ гэхээр зэрэг жинхэнэ хулгайч луйварчин, жинхэнэ гэмт этгээдүүд завшаад ингээд өнгөрдөг. Нөгөө дүлийдээ найдаад гэдэг шиг. Өө яах вэ, яах вэ, одоо тэгээд л намайг гүтгэчихсэн юм байгаа юм. Хэвлэл мэдээллээр ингэсэн. Ер нь л одоо ингэж байдаг шүү дээ. Ерөөсөө энэ улс төрийн ажил гэдэг чинь, улс төрч хүн гэдэг чинь ингэж л гүтгүүлж, доромжлуулж ингэж л байх тавилантай ийм юм шүү дээ гээд л ингээд яваад байдаг.

Гэтэл миний санахад үнэхээр энэ нийтийн албанд, ялангуяа иргэд, сонгогчдыг төлөөлж ажиллаж байгаа ийм хүмүүс бол ямарваа нэгэн жижигхэн ч гэсэн аливаа нэгэн асуудалд холбогдсон байх юм бол тэрнийхээ тэрийгээ одоо яг хар цагааныг нь ялгуулахыг төлөө араас нь явдаг. Тэрийгээ олон нийтэд мэдээлдэг. Ингээд нэг гол улсаар нь ялгаад ингээд явах юм бол өнөөдрийн нүүрсний хэрэг, Хөгжлийн банк, энэ их хулгай худал ийм зүйлүүд гарахгүй. Сэргийлж чадах ёстой л гэж би ингэж ойлгоод байдаг.

Гэтэл одоо бүр сүүлдээ хууль гаргаад ерөөсөө ямар нэгэн байдлаар энэ улс төрийн ажил алба хийж байгаа хүмүүсийг гүтгэсэн байх юм бол хуулийн байгууллагад хандаж болохгүй гэх маягийн ийм хууль санаачилна гээд ингээд яваад байна шүү дээ. Энэ бол бүр яав ч байж таарахгүй гэж хэлээд байгаа юм.

Тэр бол миний түрүүний хэлдэг дүлийдээ найддаг гэдэг шиг ийм бусдын дүйвээн дотор хулгай худлаа зүгээр хэчнээн жилээр хийгээд явдаг энэ улсуудад нэг сайхан боломж олгох гээд байна гэж би бол ингэж л ойлгоод байдаг хүн л дээ.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд асуултад хариулна.

Н.Учрал: Цахим орчин дахь гэмт хэрэг өдөр ирэх тусам өсөж байна.

Би өмгөөлөгч нартай хүртэл уулзсан. Энд ярьж болохгүй ч гэсэн олон хэргүүд байгаа. Хууль хяналтынхан ч гэсэн хэлсэн. Өсвөр насны хүүхдүүдийг цахимаар садар самуунд уруу татаад нүцгэн шалдан зургийг нь авдаг. Мөнгө төгрөг шантаажилдаг.

Өнөөдөр эцэг эхчүүд л бодох ёстой. Хүүхдүүд чинь компьютерынхоо цаана, гар утасныхаа цаана юу хийж байна гэж бодож байна. Хоёр тутам мэдээллийн нэг болгон нь садар самуун сурталчилсан, гэмт хэрэг сурталчилсан, өдөөн турхирсан шинэ нийгэм бүтэж байна шүү дээ.

Тэгээд өнөөдөр сэтгүүлч нарын эрхийг хамгаалахгүй байна гэдэг ийм буруу мэдээлэл явуулж байгаа юм. Хэвлэлийн эрх чөлөөг хаасан нэг үг, үсэг ч энэ дотор байхгүй шүү дээ.

Би бүр харин хэвлэл мэдээллийнхэнд хэлсэн. Та нарыг би редакцтай бол баталгаажуулж өгөх ёстой. Энэ Монголын төр. Энэ бол 10 хүн цалинжуулдаг хэвлэл мэдээлэл. Энэ чинь 130 мянган хүний дагагчтай нэг хүн ажиллуулдаг “пэйж” биш шүү дээ. Та нар. Үүнийг чинь ялгаж салгах ёстой шүү дээ.

Редакцтай бол редакцтайг нь ялгах ёстой шүү дээ гэж хэлж байгаа юм. Өнөөдөр цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо сэтгэл сэрдхийлгэм мэдээнүүд байгаа шүү дээ.

2022 оны эхний 12 сарын 23-ны өдрийн байдлаар 34 мянга 960 гэмт хэрэг бүртгэгдсэний 34 хувь нь цахимаар үйлдэгдсэн. Эрүүгийн хуульд заасан 34 төрлийн гэмт хэргийн 7 мянга 657 буюу 90 хувь нь залилах байна шүү дээ. Цахимаар.

2.9 хүн цахим мэдээлэлд нь хууль бусаар халдсан. 126 худал мэдээлэл тараасан. 69 хувь нь цахимаар мөрийтэй тоглоом. 69 буюу 0.8 хувь нь мөрийтэй тоглоом зохион байгуулсан. Заналхийлсэн. Ийм сэрд хийлгэм жишээнүүд байна. Цахим орчинд үйлдэгдсэн хэргүүдийн 50 хувь нь л шийдвэрлэгдсэн.

Тэгэхээр энэ асуудал байгаа учраас бид үүнийг хурдан шийдэх ёстой л гэдэг утгаараа л би оруулж ирсэн юм. Яах вэ, зүгээр ингээд л нэг нэрээ мэдэгдэхгүй уул усны зурагтай хүмүүс янз бүрийн мэдээлэл явуулаад үр хүүхэд, ирээдүй хойчийг нь буруу хүмүүжүүлж байх вий гэдгээс анхаараасай гэж бодсон юм. Энд ямар нэгэн улс төржилт байхгүй. Хэвлэлийн эрх чөлөөг хаасан нэг үг, үсэг ч байхгүй.

Тийм учраас цахим орчин дахь зөрчилтэй контент гэдэг нь гээд бүр томьёолж бичсэн юм. 6 дугаар зүйл дээр.

Нэгд, Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийг гутаан доромжилсон гэж. Нэг үг. Цахим сүлжээ ашиглаж залилахыг завдсан. Хүүхдийн бие махбод, оюун санаанд сөргөөр нөлөө үзүүлэхүйц дарамталсан, уриалсан, сурталчилсан, хүчирхийлэл, садар самууныг

сурталчилсан, хүнийг заналхийлэх, амиа хорлох, бие махбодод гэмтэл учруулахыг уриалсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг сурталчилсан, хэрэглээг нь сурталчилсан, экстермист, террорист үйл ажиллагааг сурталчилсан, цахим гадуурхал бий болгосон, оюуны өмчийн эрхийн зөрчилтэй, хүүхдийг гуйлга гуйхад тэнэмэл, хараа хяналтгүй амьдрахад татан оруулсан, уриалсан гэсэн ийм л хэдэн зүйл байгаа шүү дээ.

Энэ юу юм бэ гэхээр энэ чинь фэйсбүүкийн өөрийнх нь тавьдаг коммунити стандарт. Үүнийг нь нийцүүлээд л тавьсан. Өөр юу ч энд хамаарахгүй.

Тэр байтугай энэ дотор тэр гүтгэж, доромжлохыг бид шийдэхгүй. Үүнийг бол тэр эрүү, зөрчлийн хуулиараа шийднэ. Яагаад энэ зөрчилтэй контент гэж зөвлөмж гаргах гээд байна вэ гэхээр энэ чинь явж явж байгаад гэмт хэрэг болчих вий гэдгээс сэргийлж байгаа шүү дээ.

Гэтэл тэр фэйсбүүк компани өнөөдөр бид нар луу хүсэлтээ явуулаад прокурорын дүгнэлт, шүүхийн шийдвэр иртэл чинь бид хараад байж байна гээд. Хэдэн сараар явдаг. Хэдэн сарын дараа шүүхийн шийдвэр нь очлоо гээд аль хэдийн нөгөө гэмт хэрэг, учруулж болох хохирол нь нийгмээр тэсэрчихсэн байдаг. Ингээд хүүхдүүд хохирдог, үр хойч маань хохирдог. Эх хэлээрээ бид ярьж болохоо больчихоод байна шүү дээ.

Өнөөдөр та бүхэн хар л даа. Эмэгтэй хүнийг ямар янз янзын хэллэгээр хэлдэг болчихсон байна. Энэ хүмүүс чинь. Эх хүнийг яаж хэлдэг болчихсон байна. Хүүхдүүдэд ямар их ёс бус хэллэгээр хүнийг доромжилж байдаг болчихсон байна. Энэ чинь цахим гадуурхал шүү дээ.

Г.Занданшатар: Н.Учрал гишүүн гүйцээж хариулъя. 1 минут.

Н.Учрал: Аль болгон бид ингээд суух юм бэ.

Тийм учраас би нэг зүйлийг хэлж байгаа. Намайг одоо янз бүрийн байдлаар хэлж ярьж байх шиг байна. Тэгэхдээ би Монгол төрд зүтгэж байгаагийнхаа хамгийн том гавьяаг би энэ удаа байгуулж байна гэж би итгэлтэй байгаа.

Өнөөдөр намайг шүүмжилж болох ч маргааш хойч үе маань үүгээр бахархах өдөр ирнэ гэж бодож байгаа.

Ирээдүй хойчийнхоо төлөө нэг ч гэсэн үйлдэл хийх цаг ирсэн. Нэг сар хойшлуул, нэг өдөр хойшлуул. Цахим залилан өдөр ирэх тусам өсөж байна. Цахим залилангийн хохирогчдын тоо тэр хохирлын хэмжээ 18 тэрбум төгрөгт хүрчихээд байна. Үүнийг хэн хариуцах вэ. Эсвэл нэг камер харахаараа болохгүй. Энэ болохгүй гээд дуугараад, массаа харж дуугараад. Эцсийн эцэст гэртээ зүгээр сууж байгаа, гэртээ энэ телевиз хараад сууж байгаа Монголын ард түмэн энэ хуулийг дэмжиж байгаа.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Уучлаарай. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 1 минут тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би эхний асуусан асуултаа тодорхой хариулт авлаа. Сүүлийнх нь цаг хугацаа багтаагүй юу. Хариулт авсангүй.

Миний хэлээд байгаа юм бол энэ улс төрчид нийгмийн сүлжээ нь ерөөсөө энэ тролл хаягуудаас ингээд л гүтгээд

байгаа гээд. Ерөөсөө энэ бол хэвийн үзэгдэл гээд. Тэгээд нөгөө дүлийдээ найдаад гэдэг шиг ингээд үүнийхээ цаана. Би бүгдийг нь хэлэхгүй л дээ. Цөөхөн гаршсан хулгайч, луйварчин ийм этгээдүүд тэгээд л ерөөсөө л яах вэ ингээд бид нарыг чинь, энэ улс төрийн ажил хийж байгаа улсуудыг чинь ингээд гүтгээд байдаг юм шүү дээ гэсэн ийм маягаар ингээд л ард нь сугарч үлдээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хуулийн төсөл батлагдсанаараа энэ нөхдүүдийг хариуцлагажуулах, тодорхой болгох. Үүнийг анх нэрийг нь дэвшүүлсэн байдаг юм уу, тэр улс төрийн намууд нь шаарддаг шахдаг, эсвэл иргэд сонгогчид нь шаарддаг шахдаг. Чи Дорж ийм асуудалд холбогдсон байна. Үүнийгээ хар цагаанаар нь ялгуул гэж шаарддаг шахдаг ийм юм руу энэ хуулийн төсөл чинь.../минут дуусав/

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн асуултад хариулна.

Н.Учрал: Төрийн албан тушаалтнуудыг болоод нийтийн албан тушаалтнуудыг хамгаалах хууль энэ биш. Харин ч улс төрчид янз бүрийн байдлаар тэр уул усны зурагтай янз бүрийн троллчид ажиллуулж бие биеийгээ гүтгэн харлуулдаг энэ байдал чинь яг үнэндээ улс төрчид л байгаа шүү дээ. Улс төрчдийн ард л энэ байна л гэж нийгэм шүүмжилж байна шүү дээ.

Тийм учраас өнөөдөр хэн гэдэг нь мэдэгдэхгүй хуурамч аккаунтуудаас салах цаг ирсэн.

Тийм учраас энэ хуулиар олон улсын тэр үйлчилгээ үзүүлэгч компаниуддаа баталгаажсан утасны дугаар, имэйл хаягаараа бүртгүүлэхийг л шаардана. Харилцаа холбооны хуульд ч

гэсэн бүртгэлтэй дугаараар л дугаар авдаг. Ингэж шаардаж байгаа.

Хоёрт, бие төлөөлөгчийн газраа энд байгуул гэж хүсэлт тавьж байгаа юм. 300 мянган хэрэглэгчээс дээш бол.

Тэгэхээр олон улсын тэр компанитайгаа хамтарч ажиллаад, энэ троллчдыг цэгцлэхийн төлөө. Фэйсбүүкийн энэ оны хамгийн том зорилт юм билээ. Том компанийнхан. Хуурамч аккаунтыг цэгцэлье гэж.

Г.Занданшатар: Хариулчихсан. Тийм ээ. Хариулах уу. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: энэ хуулийн төсөл өнөөдөр Улсын Их Хурал дээр орж ирж бид хэлэлцэж байна.

Энд одоо түргэвчилсэн байдлаар орж ирсэн учраас л энэ их хардлага төрүүлж нийгэмд бас энэ социал, цахим орчинд ийм маргаан, янз бүрийн асуудал гаргаад байгаа нь их ойлгомжгүй байгаа юм.

Гэхдээ өнөөдөр хуульд заасан энэ цахим орчинд, цахим орчноор дамжиж Монголын нийгэм хар бараан сүүдэрт автсан ийм цаг үед бид амьдарч байгаа. Энд манай гишүүдийн яриад байгаа, үүнийг шүүмжлээд байгаатай би санал нэг байгаа.

Гэхдээ өнөөдөр ямар нэгэн хуурамч хаягаас бусдыг гутаан доромжилдог, хүчирхийлэл, эмх замбараагүй байдал ийм юмыг өнөөдөр бид залуу үедээ нийгэмд бий болгосон энэ асуудлыг цэгцлэх шаардлагатай байгаа. Шаардлагатай байгаа.

Түүнчлэн энэ цахим орчноос болж олон асуудалтай бид тулгарч байгаа.

Ирээдүйд, цаашид ямар асуудлаар тулгарах нь ч бид бас тодорхойгүй байгаа шүү дээ.

Өнөөдөр энэ мөрийтэй тоглоомд донтох асуудал байж байна. Түүнчлэн хүүхдүүд цахим тоглоом гээд л. Энэ мэтийн асуудлыг бид бас хязгаарлаж энд нийгмийн өмнө үүрэг хүлээх ёстой. Монголын төр. Үүнийг би ойлгож байгаа.

Өнөөдөр Н.Учрал руу их дайраад байна. Дайрна. Энэ их зөв юм хийсэн ч байж болно, буруу юм хийсэн ч. Энэ бол үүргээ биелүүлсэн.

Дээр нь өнөөдөр ингээд энэ эмх замбараагүй байдалд уриалаад өнөөдөр Арабын өнгөт хувьсгал гээд бид юу болж байсныг мэдэж байгаа шүү дээ. Энэ хэдэн жилийн өмнө болсон юм чинь өнөөдөр Монгол руу сүүдрээ тусгаж байна. Гэрлээ тусгаж байна.

Энд ганцхан яаралтай горимоор өнөөдөр орж ирж байгаа асуудал л их хардлагатай байгаа.

Дээр нь бид өнөөдөр үүнийг цэгцлэхгүй, ийм асуудлыг шийдэхгүй бол бид цаашдаа яах юм. Өнөөдөр ийм учраас үүнийг олон талаас нь ярилцаад, хэлэлцээд шийдэх ёстой.

Энд ийм асуудал бий болгоход Монголын төрийн эрх барих дээд байгууллага Их Хурлын бид ч гэсэн энд буруутай. Олон хэвлэл мэдээллийн байгууллагыг бий болгодог. Янз бүрийн хуурамч хаяг нээж бусдыг гүтгэдэг бүхэл бүтэн тролл хүртэл ажиллуулдаг шүү дээ. Энд нуух юм байхгүй.

Тэгээд энэ чинь эргээд улсаа залгих, ирээдүйгээ залгих мэдээллийн ийм муухай харанхуй байдал руу бид

түлхэхээс ард иргэдээ хамгаалах нь өнөөдөр Монгол Улсын эрх ашиг байгаа.

Энэ дээр бид манай гишүүдийн ярьж байгаа шүүмжлэлийг би 100 хувь хүлээж авч байгаа. Гэхдээ үүнийг бас Монгол Улсын нийт эрх ашгийн төлөө, монголчуудын сайн сайхны төлөө бид үүнийг шийдэх ёстой. Асуудалтай тулгарна. Үүгээр бүхэл бүтэн бизнес хийдэг, бүхэл бүтэн үүгээр амьдардаг бүхэл бүтэн ийм бүлэг тийм сүрэг бий болсон байна шүү дээ. Цахим сүрэг.

Бид үүнийг цэгцлэхгүй бол хэзээ ч цэгцлэх юм. Энэ бол миний Их Хурлын гишүүний байр суурь шүү. Үүнийг бас авах гээх ухаан.../минут дуусав/

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ш.Адъяаа гишүүнд баярлалаа.

Үндэсний аюулгүй байдлын төлөө хийж байгаа үйлдлээ л гэж би бодож байгаа.

2017 оноос хойш 10 хуулийн төсөл боловсруулагдсан. Ингээд мушгин гуйвуулаад нөгөө сандарч байгаа хүмүүс сандраад оройлон ороод ирэх болохоор эмээгээд улс төрчид тэр бүр хийж чадаагүй юм шиг байгаа юм. Би бол айхгүй. Энэ хуулийг гарснаараа нийгэм эмх замбараагүй байдлаасаа салж, нэр нүүрээ гаргаж үзэл бодлоо илэрхийлдэг эрүүл орчин бий болно. Нэр нүүрээ гаргаж шүү. Тийм.

Яах вэ. Олон хүн сандарч байна шүү. Сандарч байгаа хүмүүсийг нь хараад аваарай. Сандарч байгаа. Та нар нэр нүүрээ гаргаад хүнд үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэх чинь чөлөөтэй. Харин уул усны зурагтайгаар хүүхдүүдэд янз

бүрийн бэлгийн хүчирхийлэлд уриалдаг, садар самуунд уриалдаг, залилан дуурайлдаг энэ байдлаа зогсоох ёстой шүү. Энэ улс орны эрх ашиг шүү. Хэдий болтол бид улс төржих юм. Хэдий болтол өнөөдөр олон нийтийн сүлжээн дээр 5 хүн LIVE хийсэн дээр болоод зогсчих юм. Хэдий болтол ингэж ажиллах юм. Хэдий болтол дараагийн сонгуулиа боддог байх юм.

2024 онд яах вэ дээ, Н.Учрал энэ хуулийг хийсэн гээд нөгөө сандарч байгаа хүмүүс зэрэг зэрэг LIVE-даад би сонгуульд ялахгүй байж болно. Би бол дараагийн сонгуульд ялах бол миний ерөөсөө асуудал биш. Би төрд зүтгэсэн бол үүргээ биелүүлэе л гэж бодсон.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам энэ ажлыг л хийх ёстой.

Түүнээс биш намайг e-mongolia аппликэйшнийг хөгжүүл гэж хэлээгүй шүү дээ. Сая энэ хүүхдийн мөнгөн дээр харж байгаа биз дээ. Төрийн мэдээллийн сангуудын хоорондын зөрүүтэй мэдээллийн давхардал, технологид шилжихээр илэрч байгаа биз дээ. Хорин хэдэн настай төрийн төлөө зүтгэж байгаа хэдэн залуучууд өгсөн мэдээллээр нь тавиад өгөхөд бүгд зөрж байгаа биз. Бүгд давхардаж байгаа биз. Илчлээд өгч байгаа биз дээ.

Цахим хөгжлийн яам бол авлигалыг бууруулдаг, ил тод болох ёстой нийгмийг л бүтээх гэж байгаа яам. Дээрээс нь хүний эрхийг хамгаалах ёстой.

Цахим орчинд гэмт хэрэг үйлдэж болдог гэдэг ойлголт байхгүй биз дээ. Цахим орчинд үйлдэгддэг гэмт хэрэг гэж тусдаа байхгүй шүү дээ. Нүдээрээ хараад суух юм уу.

18 тэрбумын хохирол маргааш хэд болохыг хэн тооцох вэ. Хэн дээр хохирогчдын эрх ашгийг хамгаалах вэ. Төр нь нөгөө нэг эд чинь бужигнаад ирнэ гээд л айгаад суугаад байх уу. Эцсийн эцэст энэ хуулиар бид нэг ч эрүү, зөрчлийн хуулийг хөндөөгүй шүү дээ. Үүнийг хэн ч хэнийг ч аваачиж шоронд хийчихнэ гээгүй шүү дээ. Энэ хуулиар. Энэ хууль чинь зүгээр л төр соён гэгээрүүлэх үүргээ биелүүлэе гээд бүлэг оруулчихсан. Энэ хууль чинь зүгээр л нэг сувгаар тэр фэйсбүүктэйгээ олон нийтийн сүлжээтэйгээ харилцаа гэдэг сувгийг л тодорхой болгочихсон шүү дээ. Олон нийттэй харилцах нэгжээ байгуулаад гэмт халдлагатай тэмцье л гэж байгаа шүү дээ. Улс орон.

Өнөөдөр сая Орос, Украины нөхцөл байдлыг харж байгаа биз. Одоо тэр буу зэвсэг барьдаг дайн байхгүй шүү дээ. Энэ дэлхийд. Кибер орчинд л үүсэж байна.

Үндэстнийг мөхөөх хамгийн том бодлого гэдэг чинь кибер орчинд явж байна шүү. Ойлгох хэрэгтэй байх. Бид нар. Кибер орчинд дотор нь орж эмх замбараагүй байдал үүсгэж байж хагалан бутаргадаг тэр хаус төлөв байдалд шилжүүлдэг ийм гаднын бодлого чинь аль хэдийн ороод ирчихсэн шүү дээ. Кибер орчинд. Тэгээд хараад суух уу. Гэтэл 80 хувь нь социалаар дамжаад байдаг. Тэгээд нөгөө нэг хэд маань ойворголон ороод ирэх байх гээд айгаад татах уу. Одоо LIVE хийгээд намайг янз бүрээр яриад.

Битгий мушгин гуйвуул. Би энд хариуцлагаа хүлээж байна. Энэ хуульд хүний эрхийг хамгаалсан заалт 80 хувьтай, хохирогчдыг хамгаалсан заалттай. Энэ хуульд төрийн үүргийг тодорхой болгосон. Төрийн үүргийг. Төр ямар хариуцлага хүлээх юм. Хүний

эрхийг хамгаалахад. Хэвлэлийн эрх чөлөөг сөрсөн бүр нэг үг, үсэг ч байхгүй шүү. Харин ч үүний талд редакцтай хэвлэлүүд харин үйл ажиллагаа нь баталгааждаг эхэлнэ шүү гэдгийг хэлмээр байна.

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг өнөөдөр тал талаас нь хэлэлцэж янз бүрийн байр суурь илэрхийлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэн үгээ хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

Түүнээс гадна олон нийтийн сүлжээ гэдэг бол мэдээлэл авах, мэдээлэл өгөх нэг талбар. Түүнээс гадна энэ олон нийтийн сүлжээ бол хүн хоорондын харилцааны хэрэгсэл. Энэ утгаараа эрх чөлөө нь хумигдах ёсгүй гэж ойлгож байгаа.

Нөгөө талаас нь бас илэрхийлж болно. Тухайлбал, Евро, Ази олон улсын байгууллагаас 2023 оны олон нийтийг төөрөгдөлд оруулах хамгийн хүчтэй зэвсгээр хиймэл оюун ухаанд түшиглэсэн ийм нийгмийн сүлжээний асуудал гэдгийг бас тодорхойлчихсон байна.

Улс орнууд энэ кибер аюулгүй байдал чиглэлдээ нэлээн ингээд анхаарал хандуулж байна. Гэхдээ бид үүнийг аль аль талаас нь авч үзэх ёстой. Ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдал, редакцын бие даасан байдал руу халдсан, контентод нь нөлөөлөх гэсэн ямар нэгэн ийм оролдлого байж огт таарахгүй.

Яагаад нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгслийн дунд ийм ойлголт бий болчхов оо.

Н.Учрал сайд бол бүх зүйлээ тайлбарлачихлаа. Би Хүний эрхийн Үндэсний Комисс хамгийн сүүлд нь энэ хуулийн хэрэгжилт дээр хяналт тавих, зөрчлийг нь арилгах үүрэг би Хүний эрхийн Үндэсний Комисс дээр ирнэ гэж бодож байгаа. Яагаад гэвэл энэ ерөөсөө цэвэр хүний эрхийн асуудал хөндөгдөж байгаа хуулийн төсөл.

Ж.Хунан дарга та энэ дээр ингээд хариулт өгөөч ээ. Хэрэв бид энэ хуулийн төслийг ингээд баталчих юм бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон ард иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд ямар нэгэн халдсан, хязгаарласан зүйл байна уу?

Өчигдөр бид бас 6.1 дээр ярилцсан. Үүнийг өнөөдөр засаж залруулаад ороод ирье гэсэн.

Ж.Эрхэмбаатар дэд сайдаас би энэ чиглэлд хариулт авмаар байна. Та нар ямар өөрчлөлт хийсэн бэ? Өчигдөр бас хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн зүгээр нэг энэ асуудлаар яриагүй байх. Зөрчилтэй контентын тухай яриад байгаа юм. Контентыг хэн зөрчилтэй, хэн нь зөрчилгүй гэдгийг бас хэн нэгэн дуртай хүн нь тодорхойлохгүй.

Бүхэлд нь би ямар байр суурьтай байна вэ гэвэл үнэхээр өнөөдөр энэ хуулиар юу хийх гэж байна гэвэл хуурамч хаягаар нэр нүүргүй нийтийн сүлжээнд оролцож байгаа байдлыг зогсооё. Гэмт хэргээс урьдчилан сэргийлье. Хүнийг гүтгэн доромжилдог, гэмт хэрэгт уриалан дууддаг, нийгмийн эмх замбараагүй байдал үүсгэх гэсэн аливаа оролдлогод хуулийн хүрээнд

хязгаарлалт тавьж байна гэж ойлгож байгаа болохоос хүний эрхийг хязгаарласан ийм зүйл байхгүй гэдэгт итгээд дэмжих гээд сууж байгаа.

Энэ дээр би Хүний эрхийн Үндэсний Комиссоос баталгаа авмаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд ямар нэгэн хязгаарлалт байх уу? Хүн өөрийнхөө биеэр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тэр боломж нь нээлттэй байгаа юу? Үүнийг та бүхнээс хариулт аваад дараа нь тодруулгаа хийе.

Г.Занданшатар: Н.Учрал сайд эхлээд хариулчих.

Н.Учрал: Д.Сарангэрэл гишүүнд баярлалаа. Би асуултад хариулья.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай би сэтгүүлч нартай нээлттэй уулзалт хийсэн. Бүгдийг нь урьсан. Та бүхэн саналаа хэлээч ээ гэж уулзалт хийсэн. Тэр үеэр бас яг энэ асуултуудыг асууж байсан. Би өөрөө ч гэсэн хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байсан.

Энэ хэвлэлийн эрх чөлөөг асар их хүндэтгэж явдаг хүн. Олон миний найз нөхөд хэвлэл мэдээллийн салбарт сэтгэл зүтгэл гаргаж ажиллаж байгаа.

Тийм учраас хэвлэл мэдээллийг маань харин энэ нэг хуурамч аккаунтууд гээд байгаа нөхдүүд үйл ажиллагаагаа явуулах нэр хүндийг нь унагачих вий гэдгээс би их эмзэглэдэг. Маш том редакцтай, үйл ажиллагаа явуулдаг, үндэслэлтэй, баримттай мэдээлэл дэвшүүлээд нийгэмд тавьдаг, эрэн сурвалжилт энэ сэтгүүлч нарын ачаар бид олон асуудлыг төр шийдэж чадаж байгаа. Энэ тэдний гавьяа. Тийм ч учраас тэр бол дөрөв дэх засаглал.

Тийм учраас өнөөдөр хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд энэ хууль огт алдаж болохгүй.

Тийм учраас зөрчилтэй контент гэдэг дээрээ бүр ингээд ялгаа биччихсэн юм. Энэ зөрчилтэй контент гэдгийг чинь би ингээд нэг тавьчихаад байгаа юм биш. Энэ олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нарын тавигддаг коммунити стандарт. Угаасаа фэйсбүүк бидэнтэй бидэнгүй цахим гадуурхлыг зөвшөөрдөггүй. Угаасаа бидэнтэй бидэнгүй хуурамч аккаунтыг цэгцэлье гэж зорилт тавиад хиймэл оюун ухаанаар нэг аравны бараг тав, зургаан тэрбум аккаунтыг устгачхаж. Өмнөх жилийн дотор. Хиймэл оюун ухаан ажиллуулаад.

Тэд нар юу гэдэг вэ гэхээр та нар ингээд хууль эрх зүйн орчин тодорхойгүй учраас бид монгол хэлтэй хүн хүртэл аваад ажиллуулаад энэ чинь үнэхээр садар самууныг сурталчилсан байна уу, үгүй юу. Тэр хязгаарлалт тавьдаг. Үүнийг та нартай та наргүй бид хийж байгаа гэж байгаа юм.

Тэгэхээр зөрчилтэй контент дотроо ингээд ангилаад үзчихээр үүнээс бусад нь хамаарахгүй.

Энэ хэлэлцүүлгийн явцад гишүүд санал гаргаж байсан. Гүтгэх, доромжлох байвал яасан юм бэ. Үгүй ээ. Энэ улс төрчдийг хамгаалсан хууль биш ээ. Энэ бол ирээдүй хойчоо хамгаалсан хууль.

Тийм учраас гүтгэх, доромжлох гэдэг шийдэж болохгүй ийм заалт хэрэггүй. Наадах чинь угаасаа Эрүүгийн хуулиар, Зөрчлийнхөө хуулиар явж байгаа юм гээд энд гүтгэх, доромжлох бүр нэг үг, үсэг ч тавиагүй.

Ерөөсөө тэр цахим сүлжээг ашиглаад тэр залилахыг завдаад байгаа үйлдлийг зогсоохгүй бол хохирол учирчихдаг. Жишээ нь, сая шүүхээс шийдэгдсэн хэрэг харсан. Тийм ээ. 22 мянган долларын нэг хэрэг сүүлд гарсан. Нүцгэн зургийг нь явуулж шантаажилж байгаад хүүхдээс. Тэгсээр байгаад энэ зургийг чинь тавина уу гэсээр байгаад. Нөгөө хүүхэд нь ээж, ааваасаа мөнгийг нь авч өгсөөр байгаад хорь гаруй мянган долларт хүрчихсэн. Ингээд сууж байна.

Эцэг, эхчүүд гэртээ орой ирэхэд хүүхэд нь гар утсаа оролдоод, компьютероо оролдоод юу хийгээд сууж байгааг нь мэдэж байна уу. Тэр байтугай энэ чинь мета верс гээд мета ертөнц амьдарч байна шүү дээ. Амьдарч байна шүү дээ, энэ хүүхдүүд.

Энэ орчин цаг чинь өөр ертөнцөд амьдарч байна шүү дээ. Өөр ертөнцөд. Та бид энд ингээд нэг юм яриад сууж байхад энэ ертөнц чинь өөр.

Тэгээд хэдэн хүн нийгмийг жолоодоод буруу, зөв юм руу татаад. Нэг хуулийн үг, үсгийг нь гаргаж ирэнгүүтээ мушгин гуйвуулаад буруу тайлбарлаад. Тэгээд Н.Учрал л энд нийгмийн дайсан болох гээд байгаа юм шиг.

Хэвлэлийнхэндээ би хэлье. Та нарыг би нэг үг, үсгээр ч энэ хуульд хориглоогүй шүү. Нэг үг. Хариуцлагатай хэлье. Харин олон нийттэй харилцах нэгжийг энэ хууль батлагдлаа бол би шууд нээлттэй сонгон шалгаруулна гэж бодож байгаа.

Хэвлэлийнхнийг төлөөлөн оруулчихъя. Хүний эрхийн комиссыг оруулчихъя. Сөрөг хүчний намуудаас оруулчихъя. Улс төрийн намын төлөөллийг нь оруулчихъя.

Гэхдээ мэдлэг чадвартай хүмүүсийг оруулчихъя. Өөрсдөө сонгон шалгаруулаад сонгочихъё. Тэгээд та нар маань харилц. Ингээд л нээлттэйгээр л асуудалд хандъя гэж байгаа юм.

Тэгээд тэр хүмүүс бас гуйвуулаад байсан учраас тэр 6.3 дээр. Тэр чинь уг нь нийтийн албан тушаалтан нь хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно гэсэн үг шүү дээ. Хууль дээр Хувь хүний мэдээлэл хамгаалах хуульд тэгж байдаг. Одоо үүнийг яах вэ, хэлэлцүүлгийн явцад давхар хуулиар зохицуулагдаж байгаа учраас хасаад ороод ингээд ирчихсэн. Тэгээд ер нь бол хариуцлагатай хууль.../минут дуусав/

Г.Занданшатар: Ж.Эрхэмбаатар. 82.

Ж.Эрхэмбаатар: Д.Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

Хуулийн төслийн 6.1-д зөрчилтэй контент гэсэн агуулгатай гол зохицуулалт болох энэ зөрчилтэй контентыг ялгаж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл энэ ялгалт хийгдэхээс өмнө буюу одоо энэ хууль батлагдахаас өмнө ямар нэгэн байдлаар хуульд заасан үндэслэлээр тодорхой хүсэлтийг цензуртэй авдаг ийм эрх зүйн орчин огт байгаагүй. Өөрөөр хэлбэл хэн нэгэн албан тушаалтан өөрт таалагдахгүй байгаа зүйлээ устгуулья гээд л хандаад л явж ирсэн.

Тэгэхээр энэ тодорхой зохицуулалт бий болсноороо тодорхой үндэслэлээр л хандана. Дур зоргын шинжтэй, тийм субъектив шинжтэй хүсэлтүүдийг огт авахгүй.

Энэ хууль боловсруулах явцад хэд хэдэн томъёоллууд дээр ярилцаж байгаад 6.1.1-ийг нэлээн өргөн хүрээтэй томъёолж орж ирсэн. Үүнд төрийн бэлгэ

тэмдэг, үндэсний өв соёл, зан заншил болон түүх, соёлын үнэт зүйлийг гутаан доромжилсон гэдэг агуулга тухайн контентод байвал энэ контентыг зөрчилтэй контент тооцохоор оруулж ирсэн.

Улсын Их Хурлын гишүүд болоод Байнгын хорооны бүрэн эрхийн хүрээнд тодорхой санал гараад Монгол Улсын төрийн бэлгэ тэмдэг гэдэг энэ заалт нь л үлдсэн байгаа.

Түүх, үндэсний өв соёл, зан заншилтай холбогдолтой гутаан доромжилсон хэсэг бол ингээд хасагдаад явчихсан байж байгаа. Уг нь хамгаалалтад байх ёстой гэж ингэж боловсруулж оруулж ирсэн.

6.1.3 дээр тодорхой зөрчлүүдийг мөн дурдсан. Үүнээс заналхийлэх гэдэг үйлдлийг нь, заналхийлсэн гэсэн үйлдлийг нь үлдээгээд, гүтгэх, доромжлох асуудал нь Эрүүгийн болоод Зөрчлийн хуулиар томилогддог гэдэг үүднээс хасчихсан байгаа.

Мөн зөрчилтэй контент гэдэг агуулгыг тодорхойлохдоо фэйсбүүк болоод Германы хуулиар хэд хэдэн асуудлыг анхаардаг.

Нэгдүгээрт, агуулга. Түрүүн 6.1.1 дээр дурдаад байгаа агуулга.

Мөн 6.2 дээр дурдаад байгаа зорилгыг нь хардаг гэж байгаа юм.

Тэгээд зорилгыг нь харах хүрээнд тэр мэдээллийг зориудаар зохион байгуулалтаар түгээж байна уу, үгүй юу. Тодорхой хэн нэгнийг ялгаварлан гадуурхах чиглэж зорилготой явж байна уу, үгүй юу. Эдийн засагт учруулах болоод хүний эрх, ашиг сонирхлыг хөндөх, нийгэмд үзүүлж байгаа сөрөг

нөлөөллийг анхаарч тооцсоны үндсэн дээр сөрөг агуулгатай зөрчилтэй контент гэж ингэж тодорхойлж шалгадаг. Тэгээд энэ зохицуулалтыг мөн хуульдаа суулгасан байгаа.

6.2.1 дээр нийт хэрэглэгчийн олон нийтийн сүлжээн дэх нөлөө бүхий байдлыг харгалзаж үзнэ гэсэн заалтыг хэлэлцүүлгийн явцад хасах санал гараад өнөөдөр санал хураагдах байх.

Энэ яагаад ийм заалт орж ирсэн бэ гэхээр энгийн иргэний үзэл бодлоо хэлж байгаа байдал, хор нөлөө, олон дагагчтай гэдэг юм уу, нийтийн албан тушаалтны хэлж байгаа үйлдэл, үйл ажиллагаа, хор нөлөө харьцангуй өөр байдаг. Эрүүгийн хуулийн концепц дээр ч энэ мөн ялгардаг. Харж үздэг. Одоо өөрөөр хэлбэл тухайн хүний хувийн байдлыг нь хүндрүүлэх болоод хөнгөрүүлэх нөхцөл байдал гэж үнэлдэг ийм хууль эрх зүйн орчин Монголд байдаг.

Тэгэхээр энэ байдлыг харгалзаж үзье гэсэн ийм заалт байсан.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналын хүрээнд Байнгын хороогоор энэ заалтыг хасъя гэсэн томьёололтой орж байсан.

Ингээд 6.3 бол уг нь маш хэрэгтэй заалт байсан гэж үзэж л бид оруулж ирсэн. Нийтийн албан тушаалтан өдөр тутам үйл ажиллагаа явуулахдаа хувийн хүний мэдээлэлтэй байнга харилцаж байдаг. Ингээд харилцаж байгаа мэдээллээ хэн нэгэнд ямар нэгэн зорилгоор нийтийн сүлжээнд тавиад байвал энэ нь өөрөө эргээд маш ноцтой үр дагавар үүсгэх эрсдэлтэй гэдэг үүднээс тухайн албан тушаалтны үйлдлийг нь хориглож бичсэн ийм заалт. Зүгээр энэ заалт бол одоо яг томьёоллоор

хасагдчихсан байгаа. Ийм заалтууд хасагдсан байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комисс Ж.Хунан дарга.

Ж.Хунан: Д.Сарангэрэл гишүүний асуултад хариулья.

Хуулийн төсөлтэй Хүний эрхийн Үндэсний Комисс их богино хугацаанд танилцсан байгаа. Анхаарах ёстой хэдэн асуудлууд байсан уу гэвэл байгаа. Байсан.

Өчигдрийн явцад санал солилцох Хүний эрхийн үндэсний комисс тодорхой саналуудыг гаргасан. Энэ саналуудыг үндэслээд хуулийн төсөлд өөрчлөлтүүд орсон гэж харж байна.

Хүний эрхийг хангах, хамгаалах асуудал бол төрийн үүрэг мөн. Төр энэ үүргээ бодит амьдрал дээр ч тэр, цахим орчинд ч хамгаалах ийм үүрэг хүлээсэн байгаа.

Энэ хүрээндээ энэ хуулийг гаргах хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг ойлгож байна. Өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комисст ирж байгаа, олон нийтэд ил болж байгаа, бүртгэгдэж байгаа гэмт хэргүүдийг харах юм бол бүгд цахим орчинд үйлдэгдэж байна.

Энэ нь дээрээсээ илүү хор уршгийг бий болгож байгаа. Энэ бол бодит нөхцөл байдал мөн гэвэл мөн. Өнөөдөр цахим орчинд хүний эрхийг хамгаалах хэрэгцээ шаардлага байгаа гэвэл байгаа. Энэ хэмжээгээрээ хязгаарлалтыг тодорхой хэмжээнд тогтоодог. Тэгэхдээ хүний эрхийг хязгаарлах энэ асуудал бас тодорхой хэмжээнд зарим үндэслэлүүд дээр хийгдэх ёстой. Өөрөөр хэлбэл хүний бусдын эрх, хүний эрх, эрх чөлөө,

үндэсний аюулгүй байдал гэдэг ийм үндэслэлээр хүний эрхийг зарим тохиолдолд хязгаарлаж болдог. Ийм олон улсын болон дотоодын дүрэм журмууд үйлчилж байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс хязгаарлалтуудыг хэрэгжүүлэх процесст нь оролцох зохицуулалтыг оруулж өгсөн. Өөрөөр хэлбэл журамд нь Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг заавал авч журмыг батлах гаргах. Дээрээс нь зөрчилтэй контентыг тодорхойлоход энэ зөвлөлд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн орох гэдэг ийм саналууд тусгагдаад хуулийн төсөлд орсон байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн тодруулж асууна.

Д.Сарангэрэл: Ямар ч тохиолдолд Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль маань өөрөө Үндсэн хуулиар олгогдсон үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх энэ эрхийг ямар нэгэн байдлаар хөндөж болохгүй гэдгийг Та бүхэн маань мэдэж байгаа. Тийм ээ. Энэ хуульд ч гэсэн би тийм заалт байхгүй гэдгийг сая Хүний эрхийн Үндэсний Комисс болон Н.Учрал сайдын хэлсэн үгнээс ойлголоо.

Хуурамч хаягийн ард хулчгарууд нуугддаг. Тэгэхээр энэ хуурамч хаягийг хэрхэн яаж хязгаарлах гэж байгаа вэ? Үүний тооцоолол, төсөөлөл нь ямар байгаа вэ?

Хэрвээ үүнийг зохицуулж чадах юм бол олон нийтийн сүлжээ эрүүл болох. Хэн ч бай хэний ч талаар өөрийнхөө нэр нүүрээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шүүмжлэх бүрэн

эрх нь нээлттэй байх ёстой. Энэ хуулиар би энэ эрх нээлттэй хангагдаж байгаа гэж ойлгож байгаа. Үүн дээр би бас баталгаажуулсан ийм үг авмаар байна.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд.

Н.Учрал: Зарим улсад бүр цахим мөрдлөгийн хууль байдаг юм байна.

Энэ хууль бол ерөөсөө тийм нөгөө хэрэг хянан шийдвэрлэх гээд байгаа, эсвэл одоо нэг тийм хэргийг илрүүлэх гээд байгаа хууль ерөөсөө биш.

Нөгөө цахим орчинд зөрчилтэй контентууд нь явж байгаад гэмт хэрэг болчих вий гэдгээс л урьдчилан сэргийлээд хор хөнөөлийг эртхэн бууруулах ийм л зорилготой хуулиа гэж хэлэх ёстой байх гэж би бодож байна. Өдөрт фэйсбүүкт 2 тэрбум хүн хандаж байгаа.

Тэгэхээр ер нь цаашдаа бид энд хүний эрхийг хамгаалсан заалтуудыг оруулаад. Тэгээд дээрээс нь энэ олон нийттэй харилцах нэгж нь зүгээр зөвлөмжүүдээ гаргаад эрх бүхий байгууллагуудаа ч гэсэн, тэр ногоон сувагтаа ч гэсэн, үйлчилгээ үзүүлэгч нартаа ч гэсэн туслалцаа үзүүлээд л ингэж ажилладаг ийм олон нийтийг хамарсан хараат бус зөвлөлтэй байгууллага ажиллана.

Энд нэг их одоо тийм өөр хардах сөрдэх юм байхгүй.

Г.Занданшатар: Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар. Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар хариулъя. 82.

Ж.Эрхэмбаатар: Тэгэхээр Д.Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

Хуурамч хаяг буюу эзэн бие нь тодорхойгүй хаягаас тодорхой зөрчил, гэмтлүүд байнга явдаг. Өөрөөр хэлбэл өсвөр насны үеийн хүн болж ингэж хоорондоо харилцаа үүсгэх байдлаар гэмт хэргээ үйлдэж байсан хэд хэдэн тохиолдол, кэйсүүд энд танилцуулагдаж байгаа.

Хуурамч хаягтай тэмцэхийн тулд нэгдүгээрт ногоон сувгаараа олон нийтийн сүлжээ эрхлэгч нартай албан ёсны ойлголцдог харилцаатай болно гэж эрхийн үндсийг энэ хуулиар тавьж байгаа.

Нэг үйлчилгээ эрхлэгч хэрэглэгч бол хэдэн ч хаягтай байж болно. Үүнийг хязгаарласан зохицуулалт байхгүй. Хязгаарлаж болохгүй. Фэйсбүүк бол үүнийг зөвшөөрдөггүй. Хуурамч хаяг гэдэг нь ингээд хиймэл оюун ухаанаар зориуд зохион байгуулалттай үүсгэсэн ч хаяг байдаг. Нэг бол тодорхой ашигладаггүй хаяг байдаг. Нэг бол оруулж байгаа мэдээлэл нь Монгол Улсаас оруулж байгаа боловч байршил нь өөр газар нутагт, өөр улсад.../минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. Ж.Эрхэмбаатар. 82.

Ж.Эрхэмбаатар: Оруулж байгаа мэдээлэл нь өөр улсаас оруулаад байдаг. Хаягийн бүртгэл нь, дугаар хийсэн дугаар нь өөр улс гэх мэтчилэн ингээд янз бүрийн шалгуураар хуурамч хаягийг олж илрүүлдэг. Энэ систем нь фэйсбүүк дээр ажиллаж байгаа. Энэ системтэй хамтарч ажиллах буюу илрүүлнэ гэсэн үг.

Зөрчилтэй контент гэж хэлж байгаа, тооцож байгаа боловч бусад нь зөрчилгүй байхгүй юу.

Өөрөөр хэлбэл баталгаатай хаяг гэж үзэж байгаа бол баталгаагүй хаягийг нь хуурамч гэж хаана. Баталгаатай хэсгийг нь харин баталгаатай гэдгийг нь хэлнэ буюу иргэд, хэрэглэгч нар ороод мэдээлэл авахдаа баталгаатай мэдээлэл авах эрхээр хангагдах ёстой. Өөрөөр хэлбэл энэ эх сурвалж нь баталгаатай гэдгийг баталгаажуулж өгөөд цэнхэр хаяг тэмдэгтийг нь өгнө.

Ингээд улмаар фэйсбүүктэй хамтарч ажиллах байдлаар тодорхой системийн технологийн дэвшлийг нь авах байдлаар энэ хаягтай явна.

Фэйсбүүкт харагддаг мэдээллийн урсгалууд байдаг. Энэ хаяг хаанаас мэдээлэл оруулж байна, хаана байна гээд. Өөрөөр хэлбэл бидэнд огт харагдахгүй мэдээллийг мөн фэйсбүүктэй хуваалцах бололцоог нь энэ хуулиар бий болгоно л гэж найдаж байгаа.

Тэр мэдээлэл бол мэдээж нөгөө хохирогчийг хамгаалахын тулд тэр гэмт хэрэгтнийг олж илрүүлэхэд тустай болно.

Тэгээд ер нь хаанаас ямар төрлийн зориулалт, зохион байгуулалттай яаж зохион байгуулагдаж энэ гэмт хэрэг үйлдэгдэж, энэ хандлага үйлдэгдэж байна гэдгийг тодорхой мэдээллүүд нь авна гэх зэрэг үр дүнг хүлээж байгаа юм.

Г.Занданшатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр олон нийтийн сүлжээнд хууль гарган тодорхой мэдээллийг хязгаарлах энэ үйл явц маань нэг талаас тухайн цахим орчинд ямар нэгэн халдлага, тэгээд цахим гэмт хэрэг

зэрэгт золиос болж хохирч байгаа хүмүүсийн эрхийг хамгаалж байгаа мэт боловч нөгөө талаас үзэл бодол илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болохгүй юм.

Энэ дээр онцгойлон анхаарах ёстой. Өчигдөр би бас энэ талаар үг хэлсэн. Тэр иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 20 дугаар зүйлд яг үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах үндэслэлийг зааж өгсөн байгаа.

Энэ бол Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан байдаг. Тухайлбал фактад энэ дайсагналцах, хүчирхийллийг өдөөн турхирдаг, үндсэрхэх үзлээр болон арьс өнгөөр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулгыг л хуулиар хязгаарлана гэж байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлбэл цахим орчинд мэдээллийг зохицуулах энэ хууль маань зөвхөн эдгээр үндэслэлээр буюу хуульд заасан үндэслэлээр л тодорхой хязгаарлалт хийх боломжтой.

Тэгээд манай Үндсэн хуульд одоо яг энэ үзэл бодлоо илэрхийлэх, эрхийг хязгаарлах, хүний эрх хязгаарлан хэд хэдэн зарчмуудыг тусгасан байдаг. Тухайлбал, энэхүү хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсвэл нийгмийн дэг журам, ашиг сонирхлыг хамгаалахын тулд хийгдэж байгаа бол. Хүний эрхэд тавьж байгаа аливаа хязгаарлалтыг хуулиар тодорхой зааж өгөх ёстой. Энэ хязгаарлалт маш тодорхой байх ёстой.

Түүнээс биш хэн нэгэн албан тушаалтан байна уу, хэн нэгэн этгээд энэ хуулийн заалтыг үндэслэн субъектив болон улс төрийн эрх сэдлээр хүний эрхийг хязгаарлах, үзэл бодлоо

илэрхийллийг хориглох байж болохгүй юм.

Дээрээс нь хараат бус шүүхээр хянагддаг байх ёстой. Хязгаарлалт нь яг тухайн тэр үйлдэлд буюу тохирсон зайлшгүй шинжтэй байх ёстой зэрэг ийм зарчмуудыг энэ хуульдаа хэр тусгасан юм бол оо?

Төслийг тухайлан асуух юм бол төслийн 6.1 дээр хүний заналхийлсэн, залилсан, уриалсан, сурталчилсан гэх мэт буруутай үйлдлүүдийг зөвхөн шүүхээр тогтоох ёстой. Энэ бол шүүхээр тогтоох ёстой буруутай үйлдэл байгаа.

Гэтэл энэ буруутай үйлдлийг тэр Нийтийн төв болон одоо энэ Харилцаа холбооны тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуульд орж байгаа тодорхой төрийн агентлагууд тогтоох гээд байна. Өөрөөр хэлбэл шүүхээр тогтоох ёстой эрхийг нь тодорхой байгууллагууд авчхаад байна. Энэ маань хараат бус шүүхээр шийдэх ёстой энэ механизмыг чинь зөрчөөд байгаа юм биш үү.

Хоёрдугаар асуулт нь, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 21.2.8-д нэг ийм шинэ заалт оруулж байгаа.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1.7-д заасан агуулга бүхий зөрчилтэй контентыг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтооно гэж.

Тэгэхээр энэ цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг одоо ингээд тодорхой субъектив нөлөөллөөр буюу улс төрийн сэдлээр, улс төрийн

зорилгоор хаах, хязгаарлах үндэслэл болчихвий гэдэг ийм болгоомжлол байна. Энэ яг Кибер аюулгүй байдлын тухай хуульд орж байгаа.

Энэ хоёр дээр хууль санаачлагч болон энэ ажлын хэсгээс хариулт өгмөөр байна.

Г.Занданшатар: Энэ хариултын дараа санал хураалт явуулна. Асуулт хариултын цаг дуусна. Гишүүд чуулганы танхимд цуглана уу.

Ням-Осорын Учрал сайд хариулна.

Н.Учрал: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Яг таны ярьж байгаа иргэний болон улс төрийн эрхийн тухай фактад заасан асуудлыг л энд оруулсан. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх нэг үг, үсэг ч байхгүй. Би тэрийг хариуцлагатай хэлье.

Хоёрт, зөрчилтэй контент гэж үзэж байгаа нь бол олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нарын тавьдаг коммунити стандартад нийцүүлсэн. Цахим гадуурхлыг, цахим залилан болж болзошгүй байдлыг гэж. Тэгээд хэд хэдэн заалт л байгаа.

Тэгэхээр эндээс юу гэж томъёолох ёстой вэ гэхээр энэ олон нийттэй харилцах нэгж гэдэг чинь та нар нэг л юм ойлгоорой. Өөр зөрчил, эрүү, өөр тэр процессыг ямар ч хуульд өөрчлөлт ороогүй.

Олон нийттэй харилцах нэгж гэдэг байгууллага хэн нэгнийг буруутайг тогтоох ямар ч бололцоо байхгүй. Үнэхээр тэр садар самууныг сурталчилсан, үнэхээр тэр цахим

гадуурхал бий болгосон постыг нийтлэлээ буюу энэ хууль дээр контент нийтлэх гэж байгаа юм. Түүнийг нь шэйрлэхийг нь түгээх гэж байгаа юм. Тэгэхдээ зөвхөн нийтэлсэн буюу анхны эх сурвалж нь хаанаас гарсан бэ. Тэр нь үнэхээр садар самууныг сурталчилсан байна уу гэдэг хэсэг дээр тэр олон нийттэй харилцах нэгж буюу тэр хэвлэлийн төлөөлөлтэй, хүний эрхийн хамгаалагчийн төлөөлөлтэй, тэр мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй зөвлөл нь хуралдаад энэ үнэхээр одоо ингээд зөрчилтэй контент мөн гээд зөвлөмж л гаргана. Өөр энд хаах ямар ч эрх зүйн чадамж байхгүй. Энэ нэгжид. Тийм боломж ч байхгүй. Технологийн асуудлыг энэ нэгж шийдэж чадахгүй.

Аваад яах вэ гэхээр хууль хяналтын байгууллагын шалгах асуудал байна гээд л явуулна.

Тэгэхээр та бүхэн ойлгоорой. Нэгж бол ямар ч тийм шүүхийн шийдвэр шиг ч юм уу, ямар нэгэн тийм юм байхгүй шүү дээ. Зүгээр контент дээр нь эрх бүхий байгууллагад явуулна. Эсвэл тэр олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нарт явуулна. Эсвэл ногоон суваг руу явуулна.

Тэгээд тодорхой тэр байгууллагууд нь дахиж хянаж хэлэлцээд шийдвэрлэнэ. Гол нь энэ иргэдийнхээ хүсэлт, гомдлуудыг тэд нар аваад ингээд ажиллаж байх л ийм л механизмыг л бий болгох гээд байгаа. Үүнийг дагаад соён гэгээрүүлэх ажил явах ёстой. Тэр нэгжээр дамжуулаад.

Сая Давост болсон Эдийн засгийн форумын үеэр энэ Фэйсбүүкийн Олон улсын асуудлыг эрхэлсэн Ерөнхийлөгч Ник Клегг /Nick Clegg/ гэж хүн хэлсэн байна.

Олон нийтийн сүлжээний зохицуулалтыг Америкийн баруун эрэгт байгаа нийтийн сүлжээний компаниудын инженер биш тухайн улс орны ард иргэдээс сонгогдсон хууль тогтоогч нар нь хуулиараа зохицуулах ёстой. Энэ хуулийнх нь дагуу технологийн компанийн хувьд бид дэмжлэг үзүүлж хамтарч ажиллана л гэж хэлсэн.

Энэ шинэ тутам ерөөсөө биш шүү дээ. Европын Холбоонд хэрэгжиж л байгаа хуулиуд, актууд байна, Германд, Японд хэрэгжиж л байгаа актууд байна. Үүнд нь нийцүүлээд л бусад орны жишгийн дагуу л оруулж ирсэн.

Түүнээс биш энэ нэг их тийм дэлхийд байхгүй юм би гаргаж ирчхээд л яриад байгаа юм ерөөсөө байхгүй. Үүний чинь цаана олон улсын байгууллагуудтай ажиллах хугацаа хэрэгтэй. Олон улсын байгууллагууд нь санал хүсэлтээ тавина. Хамтарч ажиллана гэдэг утгаараа энэ хууль чинь өөрөө тэр иргэний болон улс төрийн эрхийн тухай фактуудыг олон улсын гэрээ конвенцуудад нийцсэн байх ёстой учраас энэ өөрөө Цахим мөрдлөгийн хууль ерөөсөө биш байх ёстой гэж би ойлгосон юм.

Түүнээс биш олон гишүүдийн олон хуулиуд дунд бүр Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиар дагуулчихсан боломжгүй юмнууд зөндөө байсан. Харин эд нарыг нь болиод энэ боломжгүй гээд ингээд шийдсэн. Жишээ нь, өмнө нь би нэг хүүхдийг тэдгээрийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс хамгаалах хууль гээд боловсруулаад би С.Одонтуяа гишүүнд өгч байсан.

Тэгээд би О.Цогтгэрэл даргад Кибер аюулгүй байдлын орчин нөхцөлийн талаар ярих нь илүүц. Одоо надаас илүү технологи мэддэг хүн.

Тэгээд би Ардчилсан намынхаа гишүүдийг энэ асуудлыг эрүүлээр хараад хамтдаа харин хэрэгжүүлье л гэж хэлэх гээд байгаа юм. Энд улс төрийн нам хамаагүй. Үүнийг харин бүр дараа долоо хоногос би О.Цогтгэрэл даргатай хамт Сингапурт Фэйсбүүкийн Азийн захиралтай очиж уулзмаар байна.

Ингээд нийгмийнхээ төлөө, үндэсний эрх ашгийнхаа төлөө бүгдээрээ хамтраад ажиллалчихъя. Энэ эрүү, зөрчил, хэвлэлийн эрх чөлөөг ямар нэгэн асуудал хөндөөгүй шүү. Түүнийг Та бүхэн ойлгоорой.

Г.Занданшатар: Ажлын хэсгээс Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар дэд сайд. Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд.

Ж.Эрхэмбаатар: Тэгэхээр хүний эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлах ийм боломж байгаа. Энэ хууль гол нь тэр үндэслэлийг бий болгох гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ хууль байгаагүй өнөөдөр ямар нөхцөлд бид ажиллаж байна вэ гэхээр хэн нэгний дур зоргоор хэн нэгэн албан тушаалтны хүссэнээр зөрчилтэй, зөрчилгүй гэдэг ангилалд чинь хийж, тодорхой үндэслэлүүдийг зааж өгснөөр үндэслэл бий болох юм.

Хоёрдугаарт, Олон нийтийн зөвлөл зөрчилтэй контент гэдэг зүйлийг тогтоох чиг үүрэг хэрэгжүүлэхгүй. Иргэн өөрөө энэ хуулийн аль хэсэгт зааснаар өөрийн эрх ашиг хөндөгдөөд байгаа юм бэ гэдгийг тодорхойлоод хүсэлт, гомдлоо гаргана.

Ингээд хүсэлт гомдол гаргаад ирэхэд тухайн Олон нийтийн зөвлөлийн дэргэдэх нэгж маань хүсэлт, гомдлыг

хүлээж аваад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөөд цаашид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөөд шийдвэр гаргаж байгаа юм. Үнэхээр манай хуулийн энэ заалтад заасан контентын агуулгатай байна гэж иргэний хэлж байгаа зүйл нь үндэслэлтэй байна.

Тийм учраас энэ хүсэлтийг нь цаашаа үйлчилгээ эрхлэгч рүү явуулах юм. Ногоон сувгаараа дамжуулаад. Ингээд эцсийн дүндээ яг тэр контентыг устгах, үзэлтийг нь хязгаарлах шийдвэр нь тэр Олон нийтийн зөвлөлөөрөө дамжаад үйлчилгээ эрхлэгчид үүрэг болж очоод олон нийтийн сүлжээ эрхлэгч маань өөрөө энэ шийдвэрийг гаргаад хаах юм.

Энэ процессыг иргэн хийхдээ хоёр хувилбар байгаа юм.

Нэгдүгээрт, шууд өөрөө тэр үйлчилгээ эрхлэгчид хандах боломж байгаа. Ингээд хандахдаа бид бүхэн мэддэг. Жишээ аваад үзэхэд фэйсбүүк дээр тухайн контентыг болоод аккаутыг буюу хаягийг репорт хийдэг ийм тохируулга байдаг. Энэ тохируулгаараа өөрөө шууд хандах боломж нээлттэй. Нэг бол ногоон сувгаар дамжуулж хандана гэж.

Тэгэхээр энэ Олон нийтийн зөвлөлийн дэргэдэх нэгж маань өөрөө үнэн зөвийг тодорхойлоод л, гэм буруутайг тодорхойлоод л, шалгаж тогтоох гэхээсээ илүүтэйгээр ийм үүрэг хэрэгжүүлэхгүй. Ирсэн мэдээллийг хэлбэр, форматын хувьд урьдчилаад үйлчилгээ эрхлэгчидтэй тохирчихсон тэр зөв оновчтой агуулгыг нь тодорхой шалгууртай формат үүсгээд яг түүний дагуу бөглөж мэдээллийг нь тусгаад л цаашаа явуулах бараг ийм операторын л үүрэг гүйцэтгэх хэмжээнд л чиг үүрэг нь тодорхойлогдсон байгаа.

Тэгэхээр гэм бурууг тодорхойлох болоод бусад шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай ямар нэгэн байдлаар холбогдохгүй. Тэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх олж авсан шүүхийн эрхэд ямар нэгэн байдлаар хөндсөн, зөрчсөн, өөрчилсөн зүйл төсөлд тусаагүй байгаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн. Ардчилсан намын бүлгийн дарга.

О.Цогтгэрэл: Би завсарлагатай холбогдуулж үг хэлэх ёстой.

Яагаад дахин дахин завсарлагын тухай яригдаад байна вэ гэвэл яг энэ асуудал дээр, энэ хуулийн төсөл дээр маш олон тийм яагаад гэдэг асуултууд гараад байгаа юм.

Би цөөхөн ганц хоёрыг нь хэлье. Энэ хуулийг яагаад маш яаралтай горимоор ороод 02 сарын 01-нээс хэрэгжих ёстой юм бэ. Энэ үнэхээр өнөөдөр тийм нийгмийн асар тулчихсан, эдийн засгийн тулчихсан энэ олон асуудлуудаас эрэмбэ дараагаараа үнэхээр ийм өндөр асуудал мөн үү. Гурван хоногийн дотор батлаад дахиад гурав, дөрөвхөн хоногийн дотор хэрэгжиж эхлэх ёстой гэдэг. Яаралтай горим. Энэ жишээ нь олон нийт эргэлзэж байна. Гишүүд ч эргэлзэж байна.

Хоёрдугаарт нь, яг яагаад цахим сүлжээг хянах гээд байгаа юм бэ. Нөгөө нуухыг нь авах гээд нүдийг нь сохлов гэдэг гоё зүйлүүдийн тухай ярьж байгаад үүний цаана цахим сүлжээг хянах маш субъектив олон зүйл, заалттай. Хэн хэзээ, яаж хэмжиж тэр буруу агуулгатай контент гэдгийг хэн тогтоох гээд байгаа юм. Яагаад цахим сүлжээг хянах гээд байгаа юм.

Үндсэндээ жагсаал цуглаан гэдэг зүйлийг яг одоо ингэж маш яаралтайгаар хянах ийм бололцоог энэ хуулиар авах гээд байгаа юм. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй нөхцөлд цахим сүлжээг хаана. Болзошгүй гэдгийг нь хэн тодорхойлж байгаа юм. Ямар дарга тодорхойлох юм. Энэ хуулиас гадуур журмаар тодорхойлох юм уу. Гэх мэтийн. Яагаад 02 сарын 01-нээс юм. Гэх мэтийн маш олон яагаад гэдэг асуултууд энэ хуулийн төслийн олон зүйл, заалтын ард байна.

Тэгээд нийтэд нь дүгнээд хэлэхэд үүнийг олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах хууль гэхээсээ илүүтэйгээр олон нийтээс төр, засгийг хамгаалах хууль. Төр, засгийг олон нийтээс хамгаалах ийм утга агуулгатай. Төр, засаг гэдгийн цаана дарга нарыг олон нийтээс хамгаалах гэдэг ийм агуулгатай хуулийн төсөл явчихлаа гэдэг ийм л байр суурийг олон нийтийн сүлжээ ч илэрхийлж байна. Салбарынхан ч оролцож байна. Ардчилсан намын бүлэг ч бас яг ийм л байр суурьтай байна.

Тэгээд түрүүн тав хоногийн завсарлага хүсэхэд Улсын Их Хурлын дарга үдээс хойш гэдэг хугацаа өгсөн. Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу дахин 3 хоногийн завсарлага хүсье.

Г.Занданшатар: Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл гишүүн үдээс өмнө бол үдээс хойших хүртэл буюу 14.00 цаг, 2 цагийн завсарлага авсан.

Тэгээд энэ журмаараа авсан завсарлагаас завсарлагын хугацаа сунгах бол хоёр дахин бага хугацаагаар сунгадаг. 2 цагийн завсарлага авсан. Одоо 1 цагийн завсарлага өгье.

Журмаараа 1 цагийн завсарлага өгөх юм байна. 1 цагийн дараа 16 цаг 30 минутад санал хураалтаар үргэлжилнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Тэгээд 16 цаг 30 минутаас чуулганы энэ асуудлаа үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Завсарлага өгсөн учраас.

Түүний дараа хуулийн төслүүдийг эцэслэн батлах учраас гишүүд ирцээ

бүрдүүлэх хэрэгтэй. Хуулийн төслүүд эцэслэн батална.

Үүний дараа чуулганыг хааж гишүүд тойрогтоо ажиллаж, эрх зүйн шинэтгэл хийх 10 багц хуулиудын талаар ард, иргэдээ сонсох, ард түмнээ сонсох үйл ажиллагааг энэ нэг дэх өдрөөс эхлүүлэх учиртай. Ийм учраас чуулганыг завсарлуулах, чуулганы хаалтын үйл ажиллагаатай.

Гишүүд тийм учраас 16 цаг 30 минутад бүрэн бүрэлдэхүүнээрээ чуулганы танхимд цуглана.

ЗАВСАРЛАГА

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ үргэлжлэл/

Г.Занданшатар: 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн үдээс хойших хуралдаан үргэлжилж байна.

Төслийн хэлэлцүүлэг явагдаж, асуулт хариулт авч дууссан.

Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн, Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлэх үү. Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах нэртэй хууль дээр Ардчилсан намын бүлэг хоёр удаа завсарлага авсан.

Энэ хуулийг бид дахин дахин ярилцаж хэлэлцээд дэмжих боломжгүй гэдэг ийм л байр суурьтай байгаа.

Мэдээж олонх асуудлаа шийдээд явах боломжтой. Одоо бидний хувьд дахиж завсарлага авах боломж байхгүй.

Ер нь үзэл санааны хувьд аливаа нийгмийн аливаа асуудлыг хаалттай болгох тусам энэ бол түр зуурынхаа. Үүний цаана илүү том үр дагаврууд, илүү том сөрөг үр дагаврууд гардаг нь өөрөө нийгмээс гадна байгалийн ч жам. Үүний цаана тийм байдаг.

Ийм болохоор Ардчилсан намын бүлгийн хувьд иргэдийн хэлэх, мэдээлэх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх нь тодорхой хэмжээний хориг заалтууд орж байгаа энэ хуулийн төслийг дэмжих боломжгүй байр суурьтай байгаагаа дахин илэрхийлье.

Г.Занданшатар: Ажлын хэсгээс Ардчилсан намын бүлгийн завсарлагатай холбогдуулж санал ирсэн байгаа.

Энэ хууль бол ардчилсан ёс, хүний эрхийг дээдэлж, цахим сүлжээнд хүний эрхийг хамгаалахад чиглэгдэх бөгөөд хэрвээ хуулийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн байдлаар хүний эрх зөрчигдөх, хууль эрх зүйн орчин бүрдсэн эрсдэл учрах юм бол үүнийг хянаж, үнэлгээ хийх зорилгоор Улсын Их Хурлаас ажлын хэсэг байгуулж, хуулийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийхийг намуудын тэнцүү төлөөлөлтэйгөөр ажлын хэсэг байгуулж хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Хэрэгжсэн тохиолдолд.

Хоёрдугаарт, Хүний эрхийн Үндэсний Комисс болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж Олон нийтийн зөвлөлийн хяналт доор хэрэгжүүлнэ.

Ингээд хуулийн хэрэгжилтийн явцад хуулийн зөрчил гарах юм бол хаврын чуулганаар намуудын тэнцүү төлөөлөл орсон ажлын хэсэг тухайн хүний эрхийн зөрчилтэй заалтыг өөрчлөх саналыг оруулж эхний ээлжид хэлэлцүүлж өгөхийг хүсэж байна гэсэн ийм саналууд ирсэн байна. Энэ санал бол зарчмын хувьд зүйтэй.

Ер нь ардчилсан ёс, хүний эрхийг дээдэлж ажиллах зарчимтай. Мэдээж үндэсний аюулгүй байдал, төрийн аюулгүй байдал, хүний аюулгүй байдлын асуудал бүгд уялдаа холбоотой.

Ийм учраас энд байгаа заалтууд хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэнгүй бөгөөд бусад хуулиудаар илүү хориотой байсан заалтуудыг илүү зөөлрүүлсэн. Одоо хураагдах 6 санал хураалтаар иргэдийн олон нийтийн зүгээс гарсан шүүмжлэлүүдийг харгалзан үзэж залруулж өөрчилж байгаа ийм 6 санал хураалт явуулах юм байна.

Ингээд Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Энэ 6 санал дээр иргэдийн зүгээс шүүмжлэлтэй байгаа олон асуудлуудыг шийдвэрлэсэн байна.

Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж гишүүд бас үг хэлж болно. Дэмжсэн, дэмжээгүй гурав хүртэлх гишүүн үг хэлж болно. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Асуулт, хариултын цаг дууссан учраас гишүүд танхимд цуглая.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.хүнийг заналхийлэх, амиа хорлох, бие махбодод нь гэмтэл учруулахыг уриалсан, сурталчилсан;” гэсэн ийм заалт байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор орсон. Мөн иргэдийн зүгээс шүүмжлэлтэй хандаад байгаа тэр “Нийтийн албан тушаалтан хүний хувийн мэдээллийн нууцыг зөвшөөрөлгүй задлан мэдээлэхийг хориглоно.” гэсэн заалтыг бас хасаж байгаа юм байна.

Тэр тархацыг бууруулах зорилготой гэсэн юмнуудыг бас өөрчилж байгаа юм байна. Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтоохоор Хүний эрхийн Үндэсний Комиссын оролцоог хангасан заалт орж байгаа юм байна.

Ингээд санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Асуулт, хариулт дууссан. Гишүүн ээ. Түүрүүн дууссан. Тийм.

Тэгээд харин асуулт биш саналууд явах юм байна. Гишүүн ээ.

Тэгээд байна шүү дээ. Энэ О.Цогтгэрэл гишүүн, Д.Ганбат гишүүн хоёр бүлгээсээ 3 гишүүн гаргаад, Ардын намын бүлгээс 3 гишүүн гаргаад, 6 гишүүн энэ хуулийн хэрэгжилт, үүнийг засаж залруулах ажлуудыг хийж хэрэгжүүлэхийн хувьд анхаарч ажиллах хэрэгтэй байна. Тэгээд тэр дээр сайхан ажиллах хэрэгтэй байна.

Нээлттэй сонсголоо дуусгасан уу? Ж.Лхагвасүрэн дарга аа. Сайд, гишүүдийг дуудъя.

Жамбалын Ганбаатар сайд, Содномын Чинзориг сайд, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд, Сандагийн Бямбацогт сайд, Чимэдийн Хүрэлбаатар сайд, Баттогтохын Чойжилсүрэн сайд, Цэрэнпилийн Даваасүрэн сайд, Хаянгаагийн Болорчулуун сайд, Сайнбуянгийн Амарсайхан сайд. Баярлалаа.

Ажил хийвэл дуустал гэж. Г.Амартүвшин гишүүн түүрүүн тэнд байсан.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явах. Дэгээрээ энэ зогсох арга байхгүй. Горимын саналаар. Олонхын саналаар л зогсоох эрхтэй байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар асуудлыг хойшлуулах бол зөвхөн олонхын саналаар шийднэ. Нэг хүн шийддэггүй ийм ардчилсан зарчимтай.

Ингээд Ш.Раднаасэд гишүүн орж ирлээ. Санал хураалт явуулъя. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн. Харин тийм. Ардчилсан улс. Ардчилал шударга ёсны төлөө.

Санал хураалт. Үдээс хойших анхны санал хураалт учраас туршилтын санал хураалт явуулъя.

С.Амарсайхан сайд, Г.Амартүвшин гишүүн. Д.Батлут байсан. Д.Батлут гишүүнийг дуудъя. Х.Булгантуяа, Сайнхүүгийн Ганбаатар. Н.Ганибал, Ц.Даваасүрэн, Цэрэнпилийн Даваасүрэн, Жамъянгийн Мөнхбат, Д.Сарангэрэл, Дамдины Цогтбаатар, Ж.Чинбүрэн. Содномын Чинзориг сайдыг дууд. Содномын Чинзориг сайдыг дуудъя.

Энэ туршилтын санал хураалт байсан. Одоо санал хураалт явуулъя.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.хүнийг заналхийлэх, амиа хорлох, бие махбодод нь гэмтэл учруулахыг уриалсан, сурталчилсан;”

Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “хүсэлтийг” гэснийг “хүсэлт, шийдвэрийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

Б.Пүрэвдорж гишүүн. Өдрийн мэнд хүргэе. Ш.Адъяаа гишүүн суудалдаа суугаарай.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтын “хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг болон үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн” гэснийг “үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн” гэж өөрчлөн, үүнтэй уялдуулан 6.1.1 дэх заалтын “тэмдэг, үндэсний өв соёл, зан заншил, болон түүх, соёлын үнэт зүйлийг” гэснийг “тэмдгийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

26 гишүүн дэмжиж, 56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулан, үүнтэй уялдуулан төслийн 6.2.1 дэх заалт, 6.3 дахь хэсгийг хасаж, “6.2.2-6.2.5” дахь заалтын дугаарыг “6.2.1-6.2.4” гэж өөрчлөх:

“6.1.8.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхсан;”

Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

Асуулт, хариулт дуусчихсан. Санал байхгүй. Тийм ялгаварлан гадуурхаж болохгүй ээ л гэсэн үг.

29 гишүүнийг дэмжиж, 61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.5.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1.7-д зааснаас бусад агуулга бүхий зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээ хэрэгжүүлэх журмын Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтоох.”

Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

54.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 21.2.8 дахь заалтын “зогсоох зорилгоор хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээг” гэснийг “зогсоох зорилгоор зөрчилтэй контентын тархацыг бууруулах, хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд эдгээр арга хэмжээг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

29 гишүүн дэмжиж, 63.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт дууссан.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнга хороо шилжүүлж байна.

Энэ дээр үг байхгүй. Одоо хуулийн төслүүд эцэслэн батална. С.Бямбацогт сайд аа, Т.Аюурсайхан сайд аа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд, Чимэдийн Хүрэлбаатар сайд, Цэрэнпилийн Даваасүрэн сайдыг дуудъя. Та хэд сууж бай. Болоогүй байна. Хууль эцэслэн батална. Сайд нарыг дуудъя. Энэ үг байхгүй, байхгүй.

Ажлын хэсэгт баярлалаа. Ажлын хэсэг явж байж болно.

Ж.Хунан дарга аа, энэ хууль эцэслэн батлагдлаа. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс хүний эрхийн зөрчил байхгүй байхад онцгой анхаарч, хэрвээ хуулийн зөрчил гарвал үүнийг оруулж ирж хэлэлцүүлнэ.

Ардчилсан намын бүлгээс гишүүд. Н.Учрал сайд аа. Хуулийн хэрэгжилт дээр ажлын хэсэг байгуулж хуулийн хэрэгжилтийг хангах. Тэр Хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах ажлын хэрэгжилтэд хяналт тавьж оролцох

зорилготой ажлын хэсэг байгуулж ажиллана.

Хуулийн ямар нэгэн зөрчил гарах юм бол хууль хэрэгжсэний дараа хуулийн хэрэгжилтийг хангах нь Улсын Их Хурлын үүрэг. Үүнтэй уялдуулаад хэрвээ энэ дээр иргэдийн ярьж байгаа шиг хүний эрхийн зөрчил, үзэл бодлоо илэрхийлэх зөрчил гарах юм бол энэ хуулийг тухайн заалтуудыг өөрчлөх саналыг энэ хамтарсан ажлын хэсэг, Ардчилсан нам, намуудын бүлгүүдийн хамтарсан ажлын хэсэг хянан үзээд 03 дугаар сарын 15-нд хаврын чуулганаар хэлэлцүүлэх ийм чиглэл өгч байна.

О.Цогтгэрэл дарга аа, ингээд болж байна уу? Тийм ээ. Н.Учрал сайд ингээд ойлгочих.

Дашдондогийн Ганбат гишүүний яриад байгаа, Одонгийн Цогтгэрэл гишүүн нарын яриад байгаа үнэний хувьтай шүү. Бас хэт хурдан. Тийм учраас үүнийг анхаараарай цаашдаа.

Ингээд Дашдандог Ганбат гишүүн маань үүнийг ингээд дэмжиж байгаа юм байна. Үүнийг ойлголоо.

Санал хураалтад бэлэн үү? Жигжидийн Батжаргал, Монгол Ардын намын бүлгийн дэд дарга. Хишгээгийн Нямбаатар сайд. Энэ 5 хуулиа эцэслэн батлаад намрын чуулганы хаалтын ажиллагаа болно.

Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлаа баталчихсан. Монгол Ардын намын бүлэг. Ж.Батжаргал гишүүн ээ, М.Оюунчимэг гишүүн ээ, ирцээ бүрдүүл.

Тав.Баталсан хууль, тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулах

Баталсан хуулиудын эцсийн найруулгыг сонсьё.

“Орхоны хөндийд Шинэ Хархорин хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн эцсийн найруулга дээр санал тавих юм байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алба байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Дагалдан гарсан Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Сонссонд тооцлоо. /алх цохив/

Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Аудитын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр санал тавьсан байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Газрын хэвлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Гал зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Галын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Сонссонд тооцлоо. /алх цохив/

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Музейн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Ой нь тухайн үед нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/ Баярлалаа.

Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Үйлдвэр, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/ Баярлалаа.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ховордсон амьтан ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонгосонд тооцлоо. /алх цохив/

Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Холбогдуулан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр санал тавих юм байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Өдоо санал хураалт явуулна. Гишүүд гишүүд санал хураалтад бэлдье.

С.Амарсайхан сайд байсан. Одоо хууль эцэслэн батлах санал хураалт явуулна. Ж.Ганбаатар сайд аа, энэ

Ч.Хүрэлбаатар сайд, Нямбаатар сайд хоёрыг дуудаач.

Чуулганы хаалтын ажиллагаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт хууль эцэслэн батлах санал хураалттай.

Зургаа.Хуулийн төсөл эцэслэн батлах

/Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/

Г.Занданшатар: Одоо санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-г заасны дагуу нэгдсэн хуралдаанд төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Ингээд санал хураалт явуулна. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Эхлээд төхөөрөмжийн шалгалт, туршилтын санал хураалт явуулъя. /алх цохив/

Энэ Д.Цогтбаатар гишүүний юунд туслаарай. Эсрэг гараад байдаг шүү. Сая эсрэг гарчихсан байна.

Ингээд хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналыг нь томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Сайнбуянгийн Амарсайхан гишүүн үг хэлье.

С.Амарсайхан: Дэмжиж өгсөн санал ороогүй учраас дахин санал. Энэ саналыг хүчингүй болгож өгөх горимын санал гаргаж байна.

Г.Занданшатар: Төхөөрөмжийн найдвартай байдлыг дахиж шалгаарай.

Сая санал өгөөд эсрэг гараад байна гэх юм. Ингээд С.Амарсайхан гишүүний гаргасан, Сайнбуянгийн Амарсайхан гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Энэ бол С.Амарсайхан гишүүний гаргасан горимын саналыг 78.8 хувиараар дэмжлээ.

Горимын саналыг 41 хүн буюу 78.8 хувиар дэмжсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя.

Энэ бол тэгэхдээ хүний эрхийг хамгаалах асуудал бол бас аюулгүй байдлын асуудал ч гэсэн төрийн л хэрэг юм даа. Засгийн газрын ажил биш. Тэгэхээр Улсын Их Хурал.

Санал хураалтыг явуулъя. /алх цохив/

Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Д.Цогтбаатар гишүүн хоёулаа та хоёрынх санал эсрэг гарсан юм байна. Тийм ээ.

Д.Цогтбаатар: Болохгүй байна.

Г.Занданшатар: Д.Цогтбаатар гишүүн, Ц.Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Энэ төхөөрөмжнөөс сая хоцроод санал өгчихлөө. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Г.Занданшатар: Ц.Мөнхцэцэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулья.

73.1 хувийн саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Одоо санал хураалтыг дахиж өгнө. Санал хураалт. /алх цохив/

40 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Одоо хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томилолоор санал хураалт явуулья. /алх цохив/

Миний санал. Дэмжиж өгсөн боловч эсрэг гарсан байна. Тийм учраас энэ бас нөгөө нааш цааш бас юу яаж байгаад хожимдоод дарчихсан юм байлгүй. Хэрүүл хийж байгаад.

Одоо ингээд энэ санал хураалтыг хүчингүйд тооцох саналыг би гаргаж байна. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувийн саналаар энэ саналыг хүчингүйд тооцлоо.

Энэ төхөөрөмж дээр бас энэ хоцрох энэ тэр асуудал байна шүү. Энэ төхөөрөмжийг Тамгын газар анхаарахгүй бол. Энэ бас тэгээд хүмүүст болохоор ингээд нэг юу яагаад байгаа юм шиг харагдаад байдаг. Яг үнэн хэрэг дээрээ энэ төхөөрөмж дээр дараад байхад эсрэг гараад байгаа юмнууд байна.

69.2 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцсон.

Одоо санал хураалт. Гишүүд. Санал хураалт. /алх цохив/

40 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулья. /алх цохив/

39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт. /алх цохив/

40 гишүүн дэмжиж хууль төсөл нь батлагдлаа.

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулья. /алх цохив/

39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслүүд эцэслэн батлагдлаа. /алх цохив/

Одоо эцсийн найруулгыг сонсьё.
Эцсийн найруулга тараасан байгаа.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга сонссонд тооцлоо. /алх цохив/

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай

Долоо.Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хаалт

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын чуулган Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу ажлын 78 өдөр чуулж, өнөөдөр өндөрлөж байна.

Чуулганы нэгдсэн хуралдаан 32 удаа хуралдсан. 180 асуудал хэлэлцсэн байна. Байнгын хороод 108 удаа, Дэд, Түр хороо 8 удаа, Хянан шалгах түр хороо 9 удаа хуралдаж, 256 асуудал

хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооллоо. /алх цохив/

Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн найруулгыг сонслоо.

Одоо Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа зохион байгуулна.

Хаалт бол тэгэхдээ ажил хэргийн уулзалтууд хийж, сонгогчидтойгоо уулзах цаг эхэлж байна гэсэн үг. Намрын ээлжит чуулган завсарлаад хэлэлцүүлэх хуулийн төслүүдийнхээ талаар ард иргэдийнхээ саналыг сонсож, иргэд, сонгогчидтойгоо уулзана.

Ингээд чуулганыг хааж үг хэлье.

хэлэлцлээ. Бие даасан хууль 18, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 271, Улсын Их Хурлын тогтоол 38-ыг баталлаа.

Хянан шалгах чиг үүргийн хүрээнд 25 ажлын хэсэг үйл ажиллагаа явуулж байна. Эмийн чанар, хилийн боомт, хил, гааль, нүүрсний тээвэртэй холбоотой асуудлаар, Хөгжлийн банкны асуудлаар Хянан шалгах түр хороод байгуулагдаж, нийтийн сонсгол, хэлэлцүүлгүүд зохион байгууллаа.

КОВИД-19, хүнсний хангамж, Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн 3 Түр хороо ажиллаж, зарим нь тайлан, дүгнэлтээ гаргалаа.

Нийтдээ Улсын Их Хурлын гишүүд 88 асуудлаар 18 асуулга, 19 асуудлаар 7 асуулт тавьж, Засгийн газрын 7 мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонсож, давхардсан тоогоор Улсын Их Хурлын 47 гишүүн 180 асуулт асууж, үг хэлсэн байна.

Бүхэлдээ намрын чуулган тавьсан зорилтоо хэрэгжүүллээ гэж дүгнэж болохоор байна.

Гэхдээ улс орны нийгэм, эдийн засгийн байдал амаргүй байна. Гадаад, дотоод хүчин зүйлээс хамаарсан эрсдэлт нөхцөл байдал бүрэн арилаагүй. Авлига, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, хариуцлага тооцох, шударга бус, тэгш бус байдлыг халах, ядуурал, ажилгүйдэл, үнийн өсөлт, аж амьдралын доройтол, орлогын хомсдолыг зогсоох зэрэг шаардлагыг ард иргэд тавьж байна. Иргэдийн бухимдал, шаардлага бол шударга ёсыг нэхэж, шударга ёсны хүсэмжлэл нийт нийгмийг хамарч байгаагийн илэрхийлэл юм.

Ийм учраас өнгөрсөн 30 жилийн туулсан зам, ололт амжилт, алдаа дутагдалаа эргэн харж, сургамж дүгнэлт хийж, алдаа буруу байвал засах, Монгол Улсынхаа **ШИНЭ СЭРГЭЛТ**-ийг эхлүүлэх түүхэн хариуцлага Та бидэнд оногдож байна.

Эрүүл улс төр, хяналт-тэнцлийг зохистой хангасан засаглал, ард түмний оролцоо, ард иргэдийн хяналттай төр, гагцхүү хууль засагладаг шударга нийгэм, тогтвортой өсөлттэй эдийн засгийг цогцлоох эрх зүйн шинэчлэл чухал байна.

Үүнтэй холбогдуулан **ШИНЭ СЭРГЭЛТ-ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ**-ийн хүрээнд Эдийн засгийн чиглэлээр 3 багц хууль, Нийгмийн бодлогын чиглэлээр 3 багц хууль, Засаглал-улс төрийн реформын чиглэлээр 3 багц хууль, Төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулахад чиглэсэн 1 цогц арга хэмжээ, хууль ийм 10 чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийх шаардлага Улсын Их Хурлын өмнө тавигдаж байна.

Ингэхээр эдийн засгийн реформын чиглэлээр нэн ялангуяа Эдийн засгийн байнгын хороо анхаараад, Төсвийн байнгын хороо анхаараад эдийн засгийн чиглэлээр нэгдүгээрт ойрын хугацаанд эдийн засгийг тогтворжуулах багц хууль.

Хоёрдугаарт, эдийн засгийг либералчлах, хувийн хэвшил, хөрөнгө оруулалтыг дэмжих хууль.

Гуравдугаарт, эдийн засгийг төрөлжүүлэх ийм багц хуулиудыг хаврын чуулганаар хэлэлцэнэ.

Эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлээр аялал жуулчлал, аялал жуулчлалтай холбоотой багц хуулиуд, хөрөнгө оруулалтын хууль, хувийн хэвшлийг дэмжих багц хуулиуд, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль.

Эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр ойрын хугацаанд бүхнийг **“БҮХНИЙГ ЭКСПОРТОД”** уриан дор богино хугацаанд эдийн засгийг тогтворжуулж, валютын орох урсгалыг доор хаяж 1.0 тэрбум ам.доллараар нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, эрс шийдэмгий арга хэмжээ авах шаардлагатай.

Импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих, үнийн өсөлтийг тогтворжуулах, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татахад чиглэсэн ийм багц 3 хууль байна.

Энэ хүрээнд Ашигт малтмалын хууль, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай хуулиуд хамрагдана.

Хоёрдугаарт, нийгмийн бодлогын багц хуулиуд байна. Саяхан өргөн мэдүүлсэн нийгмийн даатгалын халамжийн багц хууль. Үүнийг ард иргэдээрээ хэлэлцүүлж, үгийг нь сонсох хэрэгтэй байна. Бүгд тойрогтоо ажиллаж.

Хоёрдугаарт нь, Боловсролын багц хууль удаан хүлээгдэж байна.

Гуравдугаарт, Нийтийн эрүүл мэндийн тухай хууль ийм нийгмийн чиглэлийн гурван багц хууль байна.

Гуравдугаарт, улс төр, засаглалыг сайжруулах чиглэлээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгагдсан Хяналт, шалгалтын хууль бол одоо хэрэгжээд явж байдаг. Нээлттэй сонсгол одоо л гурав, дөрвөн жилийн дараа жигдэрч эхэлж байна. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр заавал амилуулах шаардлагатай 17 хууль өргөн баригдаад хэрэгжээгүй байна.

Энэ хүрээнд улс төр-засаглалын чиглэлээр одоо тэр Улс төрийн намын тухай шинэчлэлийн хууль, Авлигатай тэмцэх багц хууль, Улс төрийн нам, Улс төрийн намуудын санхүүжилтийн тухай багц, цогц хуулиуд, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах багц, цогц хууль гэсэн ийм гурван багц хууль эрх зүй, засаглалын шинэчлэлийн хүрээнд хүлээгдэж байна. Энэ дээр Үндэсний баялгийн сангийн хууль ч

орно, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр амилах ёстой, хэрэгжих ёстой 17 хууль өргөн баригдаагүй, хэрэгжээгүй байна.

Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс хойш 4 жилийн хугацаанд энэ хуулиуд манаь бүрэн хэрэгжиж эхлэх ёстой.

Одоо ард түмний өмнө нэн тулгамдсан асуудал бол Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрлийн асуудал болсон байна. Тэгэхээр энэ түгжрэл, төвлөрлийг бууруулахад цахим шилжилт хийх, дэд бүтцийг сайжруулах, шинэ хот байгуулах Барилга, хот байгуулалтын яамны төвлөрөл, түгжрэлийг хариуцсан сайд нарын ажил асар их гэдгийг бид ойлгож байна. Энэ чиглэл дээр эрх зүйн шинэчлэл хийх хэрэгтэй.

Энэ багц, цогц тулгамдсан асуудлуудын ач холбогдлыг үнэлэн цэгнэсний үндсэн дээр чуулганы завсарлагаар Улсын Их Хурлаас “**Ард түмнээ сонсьё**” аяныг энэ 10 багц хуулиудын чиглэлээр аяныг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Энэ хүрээнд томилолтоор Улсын Их Хурлын гишүүн бүр тойрогтоо ажиллаж, зөвхөн тойргоороо хязгаарлахгүй ард иргэдтэйгээ уулзаж, тэдний санал бодол, байр суурийг сонсож, тулгамдсан асуудлуудыг шийдэх гарц гаргалгааг хэлэлцэж, энэ хуулийн төслүүдээ хэлэлцэж саналыг авах хэрэгтэй.

Энэ бол ард түмний оролцоотой парламент, ард түмний оролцоотой ардчиллын үндэс юм. Ардчиллыг төлөвшүүлж, хөгжүүлэхийн тулд ард түмний оролцоог хангах хэрэгтэй.

Тийм учраас гэнэт ингээд хууль орж ирээд батлагдлаа гэсэн шүүмжлэл биш эртнээс нөгөө “тайван цагт хөлс их гарвал” гэдэг шиг аливаа хуулийг ингэж завсарлагаанаар ард иргэдээрээ хэлэлцүүлж, шүүсийг нь шахаж, бөөсийг нь түүж, ингээд ийм бодитой, амьдралд хэрэгжих ийм хуулиуд хэлэлцүүлдэг болохын тулд ард иргэдтэйгээ уулзах ажил назгайрсан байна.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд КОВИД цар тахлын улмаас тойрогтоо ажиллаж, иргэдтэйгээ уулзаж чадаагүй. Тэр инерцээрээ одоо бас төр-ард иргэдийн харилцаа холбоо суларснаас төрд итгэх ард түмний илтгэл ч гэсэн сулардаг. Ийм учраас энэ эрх зүйн шинэчлэлийн талаар ард түмнийхээ саналыг сонсож Үндсэн хуульд заасан тэр ард түмний засаглах эрхийг эдлүүлж, ард түмний оролцоотой төлөөллийн ардчиллаа хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Хоёрдугаарх нь бол ард түмний **ХЯНАЛТ**-тай парламент байх энэ чиглэлийг хэрэгжүүлэхэд энэ нийтийн сонсгол. Хууль зөвхөн тогтоодог ажилд бид өнгөрсөн 30 жил анхаарч ирсэн бол 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр парламентын хяналтын чиг үүргийг шинэ шатанд гаргаж, зөвхөн хууль тогтоодог, хууль үйлдвэрлэдэг байгууллага биш баталсан хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийг хянан шалгадаг, тэр талаар нээлттэй сонсгол хийж ард түмний мэдэх эрхийг хангадаг, бодлого шийдвэрт ард түмний оролцоог хангадаг, төсвийн хөрөнгө, төр-ард түмний өмч, эх орны баялгийн хуваарилалт, зарцуулалтад ард иргэдийн хяналтыг тогтоож чадвал төлөөллийн ардчилал, парламентын төлөөллийн үүрэг жинхэнэ утгаараа хэрэгжинэ гэж 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлсэн.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль өнгөрсөн оноос хэрэгжиж эхэллээ.

Эндээс л олон шүгэл, нүүрс, оффтейк гэрээ, Хөгжлийн банк гээд олон асуудлаар шүгэл үлээж эхэлсэн. Энэ бол нотлох баримт, үйл баримтаар шалгадаг удаан хугацаагаар шалгадаг процесс. Хэн нэгэн зарладаг үйл, үйлдэл биш. Өнөөдөр нээлттэй сонсгол амжилттай хэрэгжиж нэгдүгээр шатаа Хөгжлийн банкны асуудлаар дууслаа.

Энэ бол парламентын хяналтын нэг чухал хэлбэр. Үүнийг харин зөв хэрэгжүүлэх явдлыг төлөвшүүлэх нь хэрэгтэй. Тэгэхээр Үндсэн хууль гэдэг бол батлаад л шууд хэрэгжчихдэг, өргөс авчихсан юм шиг сайн сайхан зүйл биш. Харин одоо 4 жил болоход дөнгөж соёл нь дөнгөж хэрэгжиж эхэлж байгаа. Ахиад 4 жил энэ хяналт, шалгалтын хууль, нээлттэй сонсголын арга механизмыг сайжруулах, улам төгөлдөршүүлэх ажил хийгдсээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт амилах болно.

Тийм учраас Улсын Их Хурал хяналт, шалгалтын ажилдаа цаашдаа онцгой анхаарах шаардлагатай юм. Хууль үйлдвэрлээд, батлаад байх нэг хэрэг. Нөгөө талаас, хуулийнхаа биелэлт, хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг ажил бол парламентын нэг төлөөлөх чиг үүрэг байх болно. Энэ бол төлөөллийн ардчиллын нэг чухал үүрэг функц юм.

Улсын Их Хурлын намрын чуулганаар бид Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг баталсан. Энэхүү хуулиар төсвийн шинэчлэл хийж, алдагдлыг бууруулах, төрийн хэмнэлтийг бүх шатанд хэрэгжүүлэх, шинэ хөрөнгө оруулалт хийхгүй байх, нэгэнт эхэлсэн арга хэмжээг 2023 онд багтаан дуусгах зарчмыг хуульчилсан.

Энэ бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд зүгээр нэг уриа, лоозон, Пи Ар болгохдоо биш төрийн бүх шатны байгууллага, төрийн өмчийн оролцоотой компаниудын удирдлага, санхүүгийн үйл ажиллагаанд цахим, ил тод мэдээллийн систем нэвтрүүлэх ажлыг яаралтай хийх шаардлагатай байна. Ард түмний хяналт бол албан тушаалтны хяналтаас илүү чухал. Ийм учраас үүнийг ил тод болгож, нээлттэй болгож байж ард түмний хяналт тогтоно.

Шинээр байгуулагдсан Цахим хөгжил, харилцаа холбооны яам төрийн ажил үйлчилгээнд ил тод, нээлттэй байдал, хүний эрхийг хангах, сайн засаглалыг тогтоох. Энэ хэмжээгээрээ ил тод байдлыг бий болгож засаглалыг сайжруулах үндсэн хөшүүрэг болох цахим шилжилтэд онцгой анхаарч ажиллаж байна. Үүнийг улам эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хувьцаат болон төрийн өмчит компаниудын засаглал, худалдан авалт, гэрээ хэлцэл, татвар, өр төлбөр, хөрөнгийн зарцуулалтад ил тод байдлыг хангаж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох, тэдгээрийн ТУЗ-ийг ард түмний төлөөлөл түлхүү байхаар өөрчлөн шинэчлэх нь зүйтэй гэж үзэж байна. Ард иргэдийн хяналтыг тогтоох шаардлагатай.

Ийм учраас ирэх хаврын чуулганаар төрийн өмчит компаниудад анхааруулж хэлэхэд Улсын Их Хурлын нээлттэй сонголт төрийн өмчит компаниудын санхүү, тайлан, ил тод нээлттэй байдалд, худалдан авалт, үр өгөөжийн байдалд анхаарч ажиллана шүү гэдгийг зориуд тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

Нэн ялангуяа байгалийн баялгийг үр өгөөжтэй удирдах, тэгш, шударга хуваарилах төрийн бодлого ард түмний хяналтад байж гэмээнэ сая зөв болно гэдэгт эргэлзэх хэрэггүй. Энэ бол нийгмийн сүлжээний нэг давуу тал.

Намрын чуулганаар бид Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан. Энэ хуулийг дагалдуулж тогтоол баталсан. Эх орны баялаг, эдийн засгийн өсөлтийг хангагч уул уурхайн бүтээгдэхүүний дээрэм, тонуулыг таслан зогсоох, олборлолт, үнэ, гэрээ, тээвэрлэлт нь ил тод байж, түүнийг ард түмэн хянах нөхцөл энэ хуулиар бүрдүүлсэн. Үүнийг бодитой хэрэгжүүлэх шаардлагатай. Хуулийг батлах нэг хэрэг. Хуулийн хэрэгжилтийг хянан шалгаж, хойноос нь хөөцөлдөж байх бол нэг чухал хэрэг байна.

Иргэддээ үйлчлэх төрийн ажил үүргээс эхлээд дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх Төр-хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг энэ намрын чуулганаар бид баталлаа.

Төр зарим чиг үүргээ иргэд, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх, цаашлаад эдийн засаг дахь төрийн оролцоог хязгаарлах нь төрд иргэдийн хяналт тогтоох нэг арга юм.

Эдийн засгийн либералчлал, хувийн хэвшлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх нь төрд байгаа авлига, хээл хахуулийг зогсоох, үр ашигтай болгох үндэс, чиглэл мөн.

Төрийн алба, төрийн алба хаагчдын үйл ажиллагаа ард түмнийхээ нүдэнд ил, хүсэлт шаардлагад ойр, сахилга хариуцлагатай, ёс зүйтэй байх ёстой. Энэ намрын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн ч Төрийн албаны

ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийг ирэх хаврын чуулганы эхэнд заавал хэлэлцэн батлах ёстой. Үүнд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо онцгой анхаарах ёстой. Хоёр чуулган дамнаад хэлэлцүүлэг хийгээд өдий хүрлээ. Ард түмнийхээ итгэлээс алсарсаар байгаа төрийн албаны нэр хүндийг төрийн албаны ёс зүй, сахилгын хэм хэмжээг тогтоож, иргэдийнхээ хяналтад оруулж байж сэргээнэ гэдэг итгэл үнэмшил баттай байна.

Ер нь Үндсэн хуулиас юм уу, аль эсвэл аль нэг хуулиас гэхээсээ илүү төрийн албан хаагчдын, иргэдийн ч гэсэн тэр ёс зүйн доройтол, ёс зүйн хэм хэмжээний алдагдалд аливаа зөрчил, дутагдал оршиж байгаа гэдэгт эргэлзэх хэрэггүй.

Монгол Улсад хуулийн засаглал, шударга ёс тогтоохыг ард иргэд маань шаардаж байгаа. Зүй ёсны энэ шаардлагад бодит хариу өгөхөд эрх зүйн шинэчлэлийн үндсэн зорилго чиглэх учиртай.

Энэ чуулганаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг нэн яаралтай горимоор хэлэлцэн баталсан.

Халдашгүй байдлыг нь баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага түдгэлзүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацааг зогсоож буюу үргэлжлүүлж, бүрэн эрх нь дуусгавар болсон үеэс сэргээн тооцох зохицуулалтыг тусгасан. Авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд аливаа хэлбэрээр өршөөл үзүүлэхгүй байх, төрийн байгууллагын удирдах түвшний албан тушаалтнууд авлигын гэмт хэрэг үйлдсэн бол гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх, 5-12 жил хүртэл

хугацаагаар хорих ял оногдуулах, торгох ял хэрэглэхгүй байх зэрэг санкцуудыг хуульчиллаа.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжсэн этгээдийн хөрөнгө, орлогыг хурааж 2-8 жил хорих ял шийтгэдэг зохицуулалттай болсон. Ингэснээр эрх мэдэл, албан тушаалын ард нуугдаж, хууль завшдаг байдал эцэслэгдэх боломж бүрдсэн гэж ард иргэд үзэж байна.

Одоо гэмт үйлдлүүдийг шуурхай шалган шийдвэрлэх, хуулиа хэрэгжүүлэх л чухал болоод байна.

Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд тусгагдсан хянан шалгах чиг үүргээ шинэ түвшинд гаргахад онцгой анхаарч байгааг дээр дурдсан. Энэ хүрээнд 2021 оны 12 дугаар сард батлагдсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2022 оноос эхлэн хэрэгжиж энэ хууль чухал үүрэг гүйцэтгэж байгаа.

Хөгжлийн банкны асуудлаар 2022 оны 04 дүгээр сард, хилийн боомт, нүүрсний экспорт, тээвэрлэлтийн асуудлаар өнгөрсөн оны 06 дугаар сард Хянан шалгах түр хороодыг Улсын Их Хурлаас байгуулан ажиллаж байгаа нь тодорхой үр дүнд хүрч, ард түмний мэдэх эрхийг хангаж байна.

Улсын Их Хурлаас байгуулагдсан Түр хороо нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол хийсэн. 230 шахам иргэн, хуулийн этгээд оролцож, 60 орчим хүн саналаа илэрхийлсэн. Оффтэйк гэрээнүүд ил болсон. Нүүрс хулгай гэх асуудлуудыг хянан шалгах ажил эрчимжиж байна.

Хөгжлийн банкны асуудлаар байгуулагдсан Хянан шалгах түр хороо энэ долоо хоногт таван өдөрт багтаан нотлох баримтыг шинжлэн судлах нэгдүгээр шатны сонсгол зохион байгууллаа.

Хоёр дахь шатны сонсгол 02 дугаар сард, гурав дахь шатны сонсгол 03 дугаар сард гурван үе шаттай хийгдэнэ.

Эхний шатны сонсголоор Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн зээл, түүний эргэн төлөлт, зээл олгосон албан тушаалтан, зээлдэгчид болон хамаарал бүхий этгээдүүдээс гэрчийн мэдүүлэг авсан. Зээлийн ашиглалт, зарцуулалтын байдалд хийсэн хянан шалгагч, шинжээчдийн дүгнэлтийг сонслоо.

Олны анхаарал татсан, нийгэмд дуулиан шуугиан тарьсан баялгийн хулгайн асуудал хөндөгдсөн энэ мэт хэргийг олон нийтэд ил тод болгох, нягтлан шалгахаас зайлсхийсэн, булгаж булзах, бусдад бурууг тохохыг оролдох эрх хэнд ч байхгүй. Хуулийн өмнө хүн бүр тэгш эрх, үүрэгтэй гэдгээ ягштал санаж хэрэгжүүлэх ёстой.

Ийм ч учраас Улсын Их Хурлаас ард түмний оролцоо, хяналтыг хангах зорилгоор “D-Parliament” платформ төслийг хэрэгжүүлж байна. “D-Parliament” төсөл дээр ард иргэдийн “E-Petition” буюу цахим өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэдэг журмыг манай Инновац, цахим бодлогын байнгын хороо өнгөрсөн долоо хоногийн хуралдаанаараа баталлаа.

Ингэснээрээ мянган иргэний саналаар энэ цонхонд иргэдийн санал хүсэлт, одоо цахим жагсаал хийж асуудлаар илэрхийлвэл үүнийг Улсын Их Хурал байрлуулж асуудлуудыг цахимаар

хүлээн авч, тухай бүрд нь Улсын Их Хурлаас Хяналт, шалгалтын түр хороо байгуулах, Ажлын хэсэг байгуулах, нээлттэй сонсгол зохион байгуулах, шаардлагатай хууль тогтоомжийг хэлэлцэх ард иргэдийн оролцоог хангасан ийм цахим “D-parliament” төслийг хэрэгжүүлж байна.

Үүнийг ард иргэддээ ойлгуулж, сурталчлахад Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо ажиллахдаа сайтар анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Одоогийн байдлаар 14 мянган e-mail хаягтай байнгын хэрэглэгчтэй болсон нь төдийлөн хангалттай тоо биш. Нийт иргэд маань энд оролцдог бол энэ жинхэнэ ард түмний оролцоог хангасан парламент хууль тогтоох үйл ажиллагаандаа ард иргэдийн саналтайгаар хэрэгжүүлэх ийм боломж бүрдэнэ.

Энэ ташрамд Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийг батлах, хэрэгжүүлэх, санаачлах, Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааг бодитой хэрэгжүүлэхийн төлөө чин сэтгэл өргөн ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт санаачилсан. Жамъянхорлоогийн Сүхбаатар ажлын хэсгийн даргаар ажилласан. Хэрэгжүүлж байгаа эрхэм гишүүн Баттөмөрийн Энхбаяр, Дамбын Батлут, Тогмидын Доржханд нарын гишүүддээ талархал илэрхийлье.

Улсын Их Хурал “Зөвшилцөж шийдье” зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулахаар тогтоол гаргасан.

Энэ хүрээнд ард иргэд, эрдэмтэн мэргэдээ сонсох, эрдэм шинжилгээний хурал, үндэсний зөвшилцлийн чуулган хийж, Зөвлөлдөх санал асуулгын тухай

хуулийн дагуу Зөвлөлдөх зөвлөл байгуулагдаж, ажилдаа ороод байна.

Тэгээд Зөвлөлдөх зөвлөл маань энэ асуулга, сэдвээ маш зөв тодорхойлж, ард иргэдээс маш оновчтой зөв асуулт асууж, бодлого шийдвэр гаргана гэдэгт итгэж байна.

Одоо бидэнд саад болоод байгаа асуудлуудыг асуудлуудыг тодорхойлох, тэдгээрийг хэрхэн шийдэх эрэмбэ дараа, гарц шийдлийг олохын тулд ард иргэдийнхээ санал бодлыг сонсож, зөвшилцөж, ярилцах нь хамгийн зөв зам гэж үзсэн. Гэхдээ юу асуух вэ, хэнээс юу асуух вэ, яаж зөвлөлдөх вэ гэдэг дээрээ энэ Зөвлөлдөх зөвлөл онцгой анхаарч, шинжлэх ухааны үндэстэй, нийгмийн яг тулгамдсан асуудлуудыг олж, асууж, бодлогын зөвлөмж бидэнд өгнө гэдэгт итгэж байна.

Монголчууд бид түүхэн сонголтын өмнө ирээд байна. Түүхэн сонголт хийх шаардлага монгол үндэстэнд түүхэн цаг үеүдэд тулгарсаар ирсэн. Эгзэгтэй, эдрээтэй ийм цагт монголчууд улс үндэстнээрээ, сэтгэл зоригоороо эвлэлдэн нэгдэн нягтарч, эвийн хүчээр зөвийг олж, гарцаагүй мэргэн сонголт хийсээр ирснийг бидний мэргэн түүх гэрчилнэ.

Ойроос жишээлбэл 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, 1921 оны Ардын хувьсгал, 1990 оны Ардчилсан хувьсгалыг дээд, доодын ялгалгүйгээр, нам, эвсэл харгалзалгүйгээр, харц, хар шар, хаан эзнээ хүртэл хамтран байж тэмцэж хийж ирсэн. Сонголт зөв байсан. Ялалт, ололт, амжилт, бүтээл Монголд ирж байсан.

Тиймээс бид эвлэсэн үедээ Эзэн Чингис хааны Монгол байсан. Эвдэрсэн,

бутарсан үедээ харь гүрний харьяалалд орсон Монгол байсан гэдгийг санаж, уруудсан, буруудсаны шалтгаанаа зөв оношилж, Монголоо шинээр сэргээн мандуулах энэ цагийн түүхэн сонголтоо хамтдаа хийхийн учир бид ард түмэнтэйгээ хамт зөвлөлдөж, цаашдын гарц, бодлого, шийдлээ олж, зөв арга замаа олно гэдэгт эргэлзэхгүй байна.

Бидэнд юу саад болж байгаа вэ? Энэ асуултын хариу болгож эрдэм шинжилгээний хурал дээр **65 хүн 231 санал**, үндэсний зөвшилцлийн чуулган дээр **161 хүн 358 санал** гаргасан.

Энэ бол хуримтлагдсан асуудал олон байгаагийн, тэдгээрийг шийдэхийн төлөө хүн бүр сэтгэл хүслээ шингээж буйн илэрхийлэл юм.

Эдгээр саналаас нэгийг ч орхигдуулалгүй судлан шинжилж, хэлэлцэн зөвшилцөж, зөв зүйтэйг нь Зөвлөлдөх санал асуулгаар ард иргэдээсээ асууж, тодруулж, шийдүүлэх гэж буй асуултуудад тусгах нь чухлыг тэмдэглэж хэлье.

Хөгжил дэвшлийн шинэ ирээдүйн зууны зүгийг тодорхойлох эдгээр олон асуудлыг эрэмбэлэх, шийдэх арга замыг тодорхойлоход Зөвлөлдөх санал асуулгын зорилго чиглэгдэж байгаа. Нийт ард түмнээ төлөөлж одоо бага олонлог энэ санал асуулгад оролцох байх. Тэгэхдээ Монгол төрийн энэ чухал үйл хэргийг амжилттай хэрэгжүүлэхэд, монгол түмэн хөгжлийн түүхэн сонголтоо хийхэд нь бүх шатны төрийн байгууллага, албан хаагчид, түүний дотор ардаа төлөөлсөн Улсын Их Хурал, ард түмний элч, төлөөлөгчид болсон Улсын Их Хурлын гишүүд онцгой хариуцлагатай, идэвхтэй хандаж оролцох ёстойг эцэст нь онцлон тэмдэглэе.

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага. Эндээс бүх бодлого, хууль, түүний хэрэгжилт, хяналт шалгалт эхэлнэ.

Ингээд Та бүхэндээ, Улсын Их Хурлын гишүүддээ ажлын өндөр амжилт хүсэж, тойрогтоо ажиллаж, ард түмнээ сонсож, ард түмнийг төлөөлөх элчийнхээ

хувьд энэ өөрчлөлт, шинэчлэлтийн төлөө эвийн хүчээр ихийг бүтээхийг хүсэн ерөөе.

Монгол Улсынхаа нийт ард иргэд, Эрхэм гишүүд Та бүхэндээ сайн сайхныг хүсэж, удахгүй тохиох уламжлалт Цагаан сарын баяраа хотол олноороо тэгш дүүрэн угтахын ерөөл дэвшүүлье.

Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулган өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаан 3 цаг 37 минут үргэлжилж, 18 цаг 05 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД